



БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Сайн туршлагын эмхэтгэл



Save the Children



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



From
the People of Japan



THE WORLD BANK
IBRD · IFC · IDA · ICGD

ДАА 155.4
ННА 88.8
У-457

“Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага
боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Сайн туршлагын эмхэтгэл

ISBN 978-99978-59-03-7

Улаанбаатар хот
2017 он

ГАРЧИГ

ГЭР БҮЛИЙН ОРЧИНД СУРГУУЛЬД БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГА

1.	Архангай аймгийн Өндөр-Улаан сум: Номын баяжилт.....	8
2.	Архангай аймгийн Хашаат сум: Хот айлын сургалт	9
3.	Архангай аймгийн Тариат сум: Нөхөрсөг захидал	10
4.	Архангай аймгийн Цэцэрлэг сум: Гэр цэцэрлэг	11
5.	Архангай аймгийн Эрдэнэмандал сум: Номын өргөөний баяжилт	12
6.	Дорнод аймгийн Халхгол сум: АХА тэмцээн.....	13
7.	Өвөрхангай аймгийн Баянгол сум: Хуучин номоор шинэ ном хийе	14
8.	Өвөрхангай аймгийн Баян-Өндөр: Сурвалжлагч шувуухай	15
9.	Өвөрхангай аймгийн Баян-Өндөр: Ярианы схем.....	16
10.	Өвөрхангай аймгийн Богд сум: Эцэг эхийн дэмжих бүлэг	17
11.	Өвөрхангай аймгийн Бүрд сум: Юмхнаар юм хийе	18
12.	Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сум: 12 жил тогтоолгох аргачлал	19
13.	Өвөрхангай аймгийн Сант сум: Үлгэрээр дамжуулж хүүхдийг хөгжүүлэх нь	20
14.	Өвөрхангай аймгийн Тарагт сум: Даалгаврын дэвтэр	22
15.	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум: Хуруун хүүхэлдэй.....	23
16.	Сүхбаатар аймгийн Мөнххаан сум: Баримлын шаврыг амилуулья.....	24

ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГА

17.	Архангай аймгийн Өлзийт сум: Аавуудын оролцоо	26
18.	Архангай аймгийн Хайрхан сум: Цаасан хуймал	27
19.	Архангай аймгийн Хотонт сум: Илтгэлийн индэр	28
20.	Архангай аймгийн Тариат сум: Хүүхэд нэг бүрийн ахицын үнэлгээ	29
21.	Архангай аймгийн Эрдэнэмандал сум: Хүссэн зүйлээ сурах боломж	30
22.	Дорнод аймгийн Матад сум: Хөгжилтэй дуран-Шидэт үзэг	31

23. Дорнод аймгийн Сэргэлэн сум: Миний ширээний ном.....	33
24. Дорнод аймгийн Сэргэлэн сум: Элч бялзуухайн жиргээ	34
25. Дорнод аймгийн Халхгол сум: Таны цаг	36
26. Дорнод аймгийн Чойбалсан сум: Миний хөгжлийн хөтөч	38
27. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум: Хөгжил, төлөвшлийн гэрчилгээ	40
28. Өвөрхангай аймгийн Сант сум: Бяцхан ОНБЗ	41
29. Өвөрхангай аймгийн Тарагт сум: Бидний тоглоом	42
30. Өвөрхангай аймгийн Уянга сум: 14 хоногийн ахиц, амжилтыг дүгнэх нь	43
31. Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум: Алдаагүй бичиж сурья	45
32. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум: Шагайн богц	47
33. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум: Хүүхэд хөгжил	49

БАГА БОЛОВСРОЛ НӨХӨН ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГА

34. Архангай аймгийн Жаргалант сум: Гэрээр боловсрол нөхөн эзэмших нь	52
35. Дорнод аймгийн Матад сум: Сурахад хэзээ ч оройтдоггүй	53
36. Өвөрхангай аймгийн Уянга сум: Боловсрол-хүүхэд нас	55
37. Сүхбаатар аймгийн Онгон сум: Амьдрах ухааны сургалтыг хөтөлбөртэй хослуулах нь	57
38. Сүхбаатар аймгийн Уулбаян сум: Хүүхэд бүр сурч чаддаг	59

ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨЛ, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ГАРСАН САЙН ТУРШЛАГА

39. Архангай аймгийн Өндөр-Улаан сум: Төслийн тогтвортой байдлыг хангах нь	62
40. Архангай аймгийн Хангай сум: ОНБЗ-ийнхний хамтын ажиллагаа	63
41. Дорнод аймгийн Цагаан-Овоо сум: ОНБЗ, орон нутгийн удирдлагын хамтын ажиллагаа	66
42. Өвөрхангай аймгийн Уянга сум: СӨББ, сургуулийн залгамж холбоо	68

ТОВЧИЛСОН ҮГ

БАЗАН	Бага ангийн заах аргын нэгдэл
ББНОХ	Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГБОСБХ	Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МНӨ	Миний номын өргөө
МУГБ	Монгол Улсын Гавьяат багш
НТБТ	Насан туршийн боловсролын төв
НТБҮТ	Насан туршийн боловсролын үндэсний төв
ОНБЗ	Олон нийтийн боловсролын зөвлөл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
ХБЦНХ	Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХХТ	Хүүхэд хөгжлийн танхим

ӨМНӨХ ҮГ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр нь Дэлхийн Банкны итгэлцлийн сан болох Японы нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай хамтран Архангай, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн алслагдсан 30 суманд хэрэгжүүлж байна.

Тус төсөл нь дээрх дөрвөн аймгийн боловсролын хамрагдалт, хүртээмж доогуур байгаа сумдын малчин өрхийн 5-10 насны хүүхдүүдийн боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд төслийн хүрээнд хүүхдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр, хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг боловсруулан, нэвтрүүлээд байна.

Төслийн хүрээнд зорилтот сум бүрт шинээр байгуулагдсан Олон нийтийн боловсролын зөвлөлийн гишүүдийн санаачилгаар дээрх гурван хөтөлбөрийн хүрээнд маш олон шинэлэг туршлагауд бий болжээ. Үүний зэрэгцээ нутаг орон бүр үйл ажиллагаагаа цаашид тогтвортой явуулж, нутагшуулан авч үлдэх арга замыг эрэлхийлж байгаа тул энэхүү эрэл хайгуулд нэмэр болох үүднээс Олон нийтийн боловсролын зөвлөлүүдийн санаачлан хэрэгжүүлж буй шинэлэг үйл ажиллагаанаас Та бүхэнд танилцуулж, энэхүү шинэ санаачилгуудыг эмхэтгэн гарын авлага болгон хэвлүүлж байна.

Энд танилцуулж буй арга туршлага нь хөдөө орон нутагт тодорхой хугацаанд туршигдаж, хүүхэд, эцэг эхчүүдэд үр дүнгээ өгсөн бодитой үйл ажиллагаа байсан юм. Тухайн үйл ажиллагааг санаачлагчид, хэрэгжүүлэгчдэд дээрх төслийг амжилттай хэрэгжүүлэхэд сэтгэл зүрхээ зориулан бидэнтэй хамтран ажилласанд ХИС-гийн хамт олон талархал илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсье.

1 ГЭР БҮЛИЙН ОРЧИНД СУРГУУЛЬД БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГА





Сайн туршлага: **НОМЫН БАЯЖИЛТ**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН
ӨНДӨР-УЛААН СУМ**

АГУУЛГА: Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ)-ийн гишүүд санаачлан Өндөр-Улаан суманд үйл ажиллагаа явуулж байгаа 5 байгууллага, ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн багш, ажилчдын дунд Хүүхэд хөгжлийн танхим (ХХТ), Миний номын өргөө (МНӨ)-нд номын хандив цуглуулах “Хүүхдийн төлөө за гэж хэлье” 14 хоногийн аян зарласан юм. Аяны хүрээнд сумын төрийн байгууллагуудад

зориулан ОНБЗ удирдамж боловсруулж, удирдамжийн дагуу номоо хүлээн авч, 350 гаруй ном цуглуулав. Хамгийн идэвхтэй, сэтгэл гаргаж оролцсон байгууллагыг 6 сарын 1-ний үр дүнгийн баярын тайлант өдөрлөгөөр өргөмжлөл гардуулан алдаршуулсан юм.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ХХТ, МНӨ-д хүүхдүүд унших номын нөөц фондтой болсон. Хүүхдүүд уншсан номын тэмдэглэл хөтлөх, дүрийн тоглолт хийх зэргээр хөгжиж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Иргэд, олон нийтийн дэмжлэг авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Үүний тулд байгууллагуудыг ХХТ, МНӨ-гөөр аялуулах, нөхцөл байдлыг үзүүлэх хэрэгтэй. Мөн төсөл хэрэгжүүлэгчид бидний хүүхдийн боловсролд анхаарч, сэтгэл гаргаж байхад бид ч бас ийм сэтгэлээр ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийх хэрэгтэйг ойлгуулах, сэтгэлийг хөндөх хэрэгтэй.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: 2 жил тутамд иргэдээс хандив босгон баяжилт, шинэчлэлт хийх, тохижуулах ажлыг төлөвлөгөөндөө тусган оруулж хийнэ. Аяныг мянгат малчин, сургууль төгсөгчид, нутгийн зөвлөлийн гишүүд, нэрэмжит ойн арга хэмжээ гэх мэт тасралтгүй байдлаар хэрэгжүүлнэ.

СУРГАМЖ: Номын санч солигдож ном урагдах, алга болох, 2 дахь ХХТ-ыг байгуулсан зэргээс шалтгаалаад номын баяжилт хийх зайлшгүй хэрэгцээ үүссэн. Ингээд хандивын аян зохион байгуулах нь олон номтой болох, төслийн мэдээллээр иргэдийг бүрэн хангах 2 үр дүнд зэрэг хүрч болохыг олж харсан.

Сайн туршлага: **ХОТ АЙЛЫН СУРГАЛТ**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН**
ХАШААТ СУМ



АГУУЛГА: Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр (ГБОСБХ)-ийн хэрэгжилт, багц ашиглалтыг эрчимжүүлэх зорилгоор зуны хугацаанд чиглүүлэгч багш нар хот айлын сургалт зохион байгуулж хэвшсэн. Чиглүүлэгч багш нар багуудаа хуваарилж аваад, багийн засаг дарга нартай хамтран айлуудын байршлыг тогтоон, сургалт явуулах хот айлыг сонгож цуглуулдаг. Дараагаар нь эцэг эх, хүүхдэд хөтөлбөрийн үнэлгээ хийж, хүүхэд, эцэг эх тус бүрт зөвлөгөө өгдөг. Түүнчлэн гарын доорх материалаар гарын авлага хийж түгээн, хөтөлбөрийн хичээл тус бүрт зөвлөгөө өгч, хүүхэд, эцэг эхийн дунд сургалт зохион байгуулдаг. Шаардлагатай хүүхэд, эцэг эхтэй ганцаарчлан ажилладаг бөгөөд эцэг эхчүүдийг хүүхэдтэйгээ ажиллах арга барилд сургахын зэрэгцээ ямар хичээлийг заахад ямар бэрхшээл гарч байгаа талаар ярилцаж, эцэг эхчүүд өөрсдийн арга туршлагаа хуваалцан хамтын шийдэлд хүрдэг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Зуны хугацаанд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, үнэлгээ хийж, үр дүнд хүрсэн. Сумын төвд 1-р ангид элсэн орох хүүхдийн тоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажил болсон бөгөөд хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхчүүд хөтөлбөрийн талаар сайн сурталчилж, дараа жил нь хүүхдүүдээ хамруулах хүсэлтийг олон эцэг эхчүүд сургууль болон ОНБЗ-д тавьж, сургууль, цэцэрлэгийн залгамж холбоо сайжирсан.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Багш нар зуны хугацаанд амралтаа авдаг хэдий ч сургалт явуулах бүрэн боломжтой байдаг. Ялангуяа чиглүүлэгч багш нарыг багуудад хуваарилахдаа очиж амардаг багийг нь сонгон, гэр цэцэрлэг түшиглэн сургалтыг зохион байгуулбал илүү үр дүнтэй байдаг.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Цэцэрлэгийн явуулын багш, чиглүүлэгч багштай хамтран ажиллах, гэр цэцэрлэгийг түшиглэх, явуулын багшийн гэрээнд тусгах хэрэгтэй.

СУРГАМЖ: Цаг агаарын байдлыг сайтар судлах, мөн найр наадмын өдрүүдийг судалж, сургалт зохион байгуулах цаг хугацааг тогтоох, төлөвлөх, бэлтгэл ажлыг сайн хангах нь зүйтэй.



Сайн туршлага: **НӨХӨРСӨГ ЗАХИДАЛ**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН**
ТАРИАТ СУМ

АГУУЛГА: ГБОСБХ-т хамрагдах хүүхдүүдийн судалгааг гарган хөтөлбөрийн нээлтийг хийхээс өмнө ОНБЗ-ийн гишүүд Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-тай хамтран эцэг эхчүүдэд хүүхэд эрдэм ном сурахын ач холбогдол, эцэг эх өөрсдөө хүүхдээ сургах боломжийн талаар сонирхол татахуйц мэдээлэл бүхий захидал бичин, доор нь хэрэв танд хүүхдээ сургах хэрэгцээ байгаа бол

холбоо барина уу гээд ОНБЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын утасны дугаарыг үлдээсэн юм. Тухайн захидлыг багийн засаг дарга нараар хүргүүлсэн бөгөөд эцэг эхчүүд захидлаа авмагц утсаар холбогдож, асууж тодруулж эхэлсэн тул зорилтот өрхүүддээ хөтөлбөрт хамрагдах урилга хүргүүлсэн. Ингээд хөтөлбөрийн нээлтийг хийхэд ирц 100%-тай байж, эцэг эхчүүд сэтгэл өндөр, үүрэг амлалттайгаар хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн юм.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Эцэг эхчүүдэд хэрэгцээ байгааг нь мэдрүүлсэн учир ном, тоглоомын ашиглалт гамтай, эвдрэл багатай, өөрсдийн саналаар засаж сэлбэдэг. Хамгийн гол нь манай сумын хувьд цас зудтай хүнд нөхцөлд өвөлждөг хэдий ч цогц хөтөлбөр маань чиглүүлэгч багш, номын санч, ОНБЗ-д ямар ч ачаалалгүйгээр сайн хэрэгждэг.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Эцэг эхийн хандлагыг өөрчлөөд, мэдээлэл нөлөөллийн ажлыг сайн хийж чадвал иргэдийн оролцоо, идэвхийг аяндаа бий болгож чадна. Ингэхдээ ОНБЗ-ийн гишүүд дангаараа биш орон нутгийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг чухалчлах нь зүйтэй.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Сургууль, цэцэрлэг, ЗДТГ болон ОНБЗ-ийн гишүүдийн хамтын ажиллагааг сайжруулан, иргэдэд мэдээллийг зөв бодитой, тогтмол хүргэж, ном, тоглоомд баяжилт хийн, номын сангийн орчныг сайжруулан ажиллана.

СУРГАМЖ: Эхний жилүүдэд эцэг эхчүүд төвөгшөөсөн, хүүхэд, чиглүүлэгч багш нарын шахалтаар багцаа сольдог, зарим эцэг эх огт хамрагдах хүсэлгүй байснаас үр дүн муу гарч байсан тул үүндээ дүгнэлт хийж, гарц хайсны дүнд энэхүү үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.

Сайн туршлага: **ГЭР ЦЭЦЭРЛЭГ**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН**
ЦЭЦЭРЛЭГ СУМ



АГУУЛГА: ГБОСБХ-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн зуслангийн байршлыг судалж үзээд, хамгийн их хүүхэд хамрагдсан алслагдсан багт гэр цэцэрлэгийг 21 хоногийн хугацаатай ажиллуулж, эцэг эхийг чадваржуулах, хүүхэдтэй ажиллах аргазүйг дээшлүүлэх сургалт хийх, гарын авлага, зөвлөмж хүргүүлэх, 2 эцэг эхэд бичиг үсгийн анхны мэдэгдэхүүн олгох, хүүхдийн хөтөлбөрийн үнэлгээ хийх, зөвлөн туслах, бүтээл хийлгэх байдлаар хүүхэд, эцэг эхтэй хамтран ажиллаж, хүүхдүүд урлагийн тайлан тоглолтоо сонирхуулан, эцэг эхчүүдийн дунд уралдаан тэмцээн явууллаа. Түүнчлэн 9 сарын 1-нд хүүхдүүд, эцэг эхийн хамтарсан бүтээлээр үзэсгэлэн гарган, хүүхдүүдийн дунд зураг зурах, үлгэр ярих, баримлаар бүтээл хийх уралдаан зохион байгуулж хүүхдүүдийг, хүүхэдтэй хамгийн сайн ажилласан 3 гэр бүлийг урамшуулсан юм. Хүүхэд, эцэг эхийн дунд “Уран жиргээ”, “Аав, ээж, би”, “Хөгжилтэй буухиа”, “Гар бөмбөг”-ийн тэмцээн уралдааныг зохион байгуулснаар эцэг эх, багш, хүүхдийн хамтын ажиллагаа сайжирсан. Энэ бүх үйл ажиллагааг зохион байгуулахыг ОНБЗ-ийн гишүүд ярилцаж шийдвэрлээд ОНБЗ-ийн гишүүн, чиглүүлэгч багш, цэцэрлэгийн явуулын багш гардан ажилласан бөгөөд тус гэр цэцэрлэгийг ажиллуулахад цэцэрлэг болон багийн засаг дарга нар хамтран шаардлагатай зардлыг шийдвэрлэсэн.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Хүүхдүүд хөтөлбөрийг бүрэн судалж, багцыг ашиглаж дуусаад 1-р ангид элсэн орсон. Хөтөлбөрийн хугацаанд эцэг эхтэй өдөр бүр тулж ажиллах боломж бүрдсэн. Мөн хүүхдүүдийг нийгэмшүүлж чадсан төдийгүй эцэг эх хүүхэдтэйгээ ажиллах аргазүйд бүрэн суралцаж, сургууль, цэцэрлэгийн залгамж холбоо сайжирсан.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Малчдын зуслангийн байршлын зураглалыг гаргаж, гэр цэцэрлэг ажиллуулах багийг зөв сонгоно. 1-3 багт зэрэг ажиллуулж болох бөгөөд зуны хугацаанд гэр цэцэрлэгээр дамжуулан хөтөлбөрийн хэрэгжилт, багцын ашиглалтыг сайжруулна. Цэцэрлэгээс тухайн багт ажиллах мэргэжлийн багш гаргах ба тухайн багт очиж ажиллах замын зардлыг цэцэрлэгээс гаргах боломж бүрдэж төсөвт төлөвлөгдсөн байгаа.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Хувилбарт сургалтаар ГБОСБХ-ийг эрчимжүүлэх, явуулын багшийн ажлын үүрэгт тусгаж өгөх, жил бүр 3 багт гэр цэцэрлэг ажиллуулах боломжтой болсон.

СУРГАМЖ: Хүүхдүүдийн байршлыг зөв тогтоох, гэр цэцэрлэг ажиллуулах хугацааг оновчтой сонгох нь зүйтэй.



Сайн туршлага: **НОМЫН ӨРГӨӨНИЙ
БАЯЖИЛТ**

Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРДЭНЭМАНДАЛ СУМ**

АГУУЛГА: ОНБЗ-өөс санаачлан “1 анги – 1 ном, 1 ардын тоглоом” аян зохион байгуулж, хүүхдүүд эцэг эхийн хамтаар оролцон, анги бүр 1-2 тоглоом, үлгэрийн ном хандивлаж МНӨ-г баяжуулсан билээ. Одоогийн байдлаар 20 сэтгэхүй хөгжүүлэх шинэ тоглоом, 120 үлгэрийн номоор баяжилт хийгээд байна. Хүүхдүүд ном, тоглоомын 10 багцаа

ашиглаж дуусаад нэг үлгэрийн ном, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомыг хандивладаг уламжлал тогтсон. Түүнчлэн МНӨ 1000 шагай, хүүхэд, эцэг эхийн хамтын бүтээл болох том номуудаар баяжилт хийсэн бөгөөд номын өргөөгөө цэцгээр чимдгийн дээр “Монгол ахуй” тоглоомын булантай болсон.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: МНӨ-ний үйл ажиллагаа малчдын сэтгэлд хүрч, хэрэгцээг хангаж байгаа тул иргэд, хүүхдүүд идэвх санаачилгатай ханддаг болсон. Номын өргөөгөөр үйлчлүүлэгч хүүхэд, эцэг эхчүүд талархал илэрхийлэн сэтгэгдлээ үлдээдэг. Өөрсдийн санаачилгаар баяжилт хийх, ном, тоглоомоо цэвэрлэх ажилд оролцдог.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: МНӨ-ний үйл ажиллагааг иргэдэд сайн сурталчлах, үр дүнг таниулах, хэрэгцээг мэдрүүлэх хэрэгтэй. Хэрэгцээ шаардлагыг бүрэн ойлгосон иргэд, эцэг эхчүүд санаачилгатайгаар оролцож эхэлнэ.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Цаашид мянгат малчин иргэдэд хандах, уриалах ажлыг зохион байгуулж, ном, тоглоомын багцын шинэчлэл хийх, сумын албан байгууллагуудын дунд аян зарлах зэргээр баяжилтыг жил бүр тогтмол хийнэ.

СУРГАМЖ: МНӨ-ний үйл ажиллагаа сайн, тогтмол, иргэд, хүүхдүүдийн сэтгэлд хүрсэн байх хэрэгтэй. Баяжилт хийсэн зүйлсийн эдэлгээ, бүрэн бүтэн байдалд анхаарал хандуулж ажиллах шаардлагатай.

Сайн туршлага: АХА ТЭМЦЭЭН Хэрэгжүүлэгч: ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМ

АГУУЛГА: Халхгол сумын ОНБЗ жил бүр ГБОСБХ, ном, тоглоомын багцыг бүрэн судлуулж байгаа эсэхэд дүгнэлт хийх, эцэг эхчүүдийг идэвхжүүлэх, мэдлэгийг бататгах зорилгоор АХА тэмцээн зохион байгуулсан. АХА-д ГБОСБХ-т хамрагдаж буй 5 настай хүүхдүүдийн эцэг эх оролцох юм. АХА тэмцээнийг зохион байгуулах зарыг багийн дарга нар айл өрхүүдэд түгээдэг ба эцэг эхчүүд сумын төвд зохион байгуулах үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцдог. АХА-гийн асуултууд нь ГБОСБХ, ном, тоглоомын багцтай холбоотойгоос гадна Халхгол сумын ОНБЗ-ийн зохион байгуулсан, хийсэн ажлууд, хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг багтаасан байдаг.

Зөвхөн АХА тэмцээн зохион байгуулахаас гадна гэр бүлийн орчинд хүүхдэдээ хэрхэн ном уншиж, хамтран тоглож байгаа туршлагаас яриулж, хөгжөөнт тоглоом тоглуулж, 1 өдрийг хөгжилтэй өнгөрүүлдэг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Энэхүү өдөрлөгийг эцэг эхчүүдийн дунд зохион байгуулснаар хүүхдэдээ ГБОСБХ-ийн хичээлийг алгасахгүй зааж, ном, тоглоомыг бүрэн ашиглуулж байгаа эсэхэд дүгнэлт хийх боломжтой болдог. Мөн эцэг эхчүүдийн оролцоо ямар түвшинд байна, оролцоог хангахад юуг анхааран зөвлөн туслах боломжтой зэргээр ОНБЗ өөрсдийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийдэг юм. Эцэг эхчүүдийг чадавхжуулах, оролцоог нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, нэгдсэн ойлголт өгөх зэрэг үр нөлөөтэй.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ГБОСБХ-т хамрагдаж буй хүүхдүүдийн дунд хөгжилтэй байдлаар зохион байгуулах, хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр (ХБЦНХ)-ийн хүрээнд хүүхдүүд, багш нар, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулах боломжтой. Мөн хөгжөөнт асуулга оруулах замаар хөгжөөх болон мэдлэг олгох, хүүхдээ сургах, хандлагыг өөрчлөх боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Халхгол сумын ОНБЗ зөвхөн ГБОСБХ-ийн хүрээнд гэж хязгаарлалгүй асуултыг өөрчлөн, хүүхдүүдийн дунд, сумын иргэд олон нийтийн дунд зохион байгуулдаг болжээ.

СУРГАМЖ: Асуулгыг бэлтгэхдээ тухайн оролцогчдын боловсролын түвшин, чадварт тааруулан бэлтгэх, АХА тэмцээний дүрмийг сайн ойлгуулах, зөвхөн ГБОСБХ-ийн хичээл бус эцэг эхчүүдийн сайн мэддэг уламжлалт мал аж ахуй, танин мэдэхүйн асуултыг хөгжөөх, сэргээх байдлаар оруулах нь илүү үр дүнтэй.





Сайн туршлага: ХУУЧИН НОМООР ШИНЭ НОМ ХИЙЕ

Хэрэгжүүлэгч: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМ

АГУУЛГА: Баянгол сумын ОНБЗ-ийн гишүүд өөр өөрсдийн хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхээс гадна олон шинэлэг зүйлийг санаачлан, түүнийгээ ажил хэрэг болгон амьдралд бүтээлчээр хэрэгжүүлдэг. Үүний нэг нь сургуулийн дотуур байрын жижүүр багш Ч.Алимаа, сургуулийн номын санч Д.Хонгорзулын санаачилгаар ОНБЗ-ийн эцэг эхийн төлөөлөл

Д.Цэцэгмаа, Б.Адъяасүрэн, Ц.Жигдбаяр нар дотуур байрын багштай хамтран хуучирч хэрэглэхээргүй болсон ном, зурагнуудыг нь ашиглан хийсэн слайдан үлгэрийн ном юм. 5 настай уншиж сураагүй хүүхдүүдэд зураг хараад үлгэрээ ярихад нь тухайн ном их дэм болдог. Уншиж сураагүй хүүхдүүд зураг харан үлгэрийг дарааллаар нь цэгцтэй, өөрийнхөө үгээр ярьж сурдаг. Тэгэхээр чиглүүлэгч багш, эцэг эхчүүд хүүхэд үлгэрээ хэрхэн ярьж сурсныг шалгах, хүүхэд үлгэрийн дарааллаа мартсан үед сэргээн сануулах зэрэгт энэ ном тусалдаг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Баянгол сумын хувьд ГБОСБХ-т нийт 143 хүүхэд хамрагдаад байгаа бөгөөд дээрх хийсэн ном нь эдгээр хүүхдүүдийн эцэг эхчүүд болон багш нарт даалгавар шалгах гол хэрэгсэл болж байна. Мөн 5 настай хүүхдүүдийн ярих чадварыг хөгжүүлж, хүүхдийн хэл яриа цэгцрэхэд их тус болж байгаа аргачлал юм. Хүүхдүүд энэ слайдан номондоо их дуртай бөгөөд цаашдаа зураг харан зохион ярих, төсөөлөн баяжуулж ярих чадвар эзэмшүүлэх сайхан боломж бүрдээд байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Гарын доорх материал ашигладаг учраас хэрэгжихэд тусгай хөрөнгө мөнгө шаардахгүй. МНӨ-ний хуучирсан номоос гадна айлуудаас хуучин, урагдсан ном цуглуулан, түүгээрээ сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын бэлтгэл бүлгийн багш нар болон эцэг эхчүүдтэй хамтран номоо улам баяжуулж, бүх 5 настай хүүхдэд хэрэглүүлэх бүрэн боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: 2015 оноос эхлэн хуучирч муудсан, акталсан номоо бүтээлчээр ашиглаж эхэлсэн бөгөөд ГБОСБХ-т хамрагдаж байгаа бүх хүүхдэд багцанд нь нэмэлт баяжилт байдлаар өгч явуулж хэвшээд байна. Цаашдаа төсөл дууссан ч МНӨ-нд хуучирч акталсан номнуудаа ашиглан слайдан номнуудаа хийж, 5 настай хүүхдүүдэд хэрэглүүлэн, үлгэр ярих чадварыг нь хөгжүүлнэ.

СУРГАМЖ: Слайдан ном хийх аргачлалыг эцэг эхчүүд болон бусад номын санч, багш нарт түгээн таниулж, энэ үйл ажиллагаанд олон нийтийг хугацаа алдалгүй татан оролцуулсан бол төсөл дуусах үед бүр олон номтой болсон байх байлаа.

Сайн туршлага: СУРВАЛЖЛАГЧ ШУВУУХАЙ

Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМ**

АГУУЛГА: Сурвалжлагч шувуухай аргагүй нь ГБОСБХ-өөр хүүхдүүдээ сургуульд бэлтгэж байгаа эцэг эхчүүдийг чадавхжуулах, зэргэлдээ амьдарч буй малчин эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ ажиллах арга барилыг хуваалцахад чиглэсэн юм.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ГБОСБХ-өөр хичээллэж байгаа хүүхдүүдийн өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн байршлыг нэг бүрчлэн гаргаж, ХИС-гаас зохион байгуулсан сургалтаар бэлтгэгдсэн 5 сургагч багш газар нутгийн байршлын дагуу хүүхдээ хуваарилан авч, хариуцсан хүүхдүүдтэйгээ нэг бүрчлэн ажилладаг.

Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд эцэг эхчүүд бие биеэсээ, хүүхэд хүүхдээсээ суралцах боломжийг бүрдүүлж “Сурвалжлагч шувуухай” дэвтэр аялуулдаг. Тус дэвтэрт хүүхдүүд юу сурснаа зуран, эцэг эхчүүд өөрийн арга туршлага, санал сэтгэгдлээ бичиж, нутаг ойролцоо айлдаа өөрсдөө хүргэж өгч арга туршлагаа солилцдог. Тус хөтөлбөрт хамрагдсан 70 хүүхдийн гарааны үнэлгээнээс эцсийн үнэлгээ нь 35%-иар ахисан амжилттай байгаа бөгөөд эцэг эхчүүдийн аргагүй 70%-иар сайжирч, төслийн үр шимийг хүртэгсдийн тоо нэмэгдэж байна. Сумын малчдын 75% нь тус төслийн талаар мэдэгдэхүүнтэй болж, үр шимийг хүртэж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ГБОСБХ болон Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр (ББНОХ)-т хамрагдан хичээллэж байгаа хүүхдэд гарах үр дүн нь танхимын сургалтынхаас эцэг эхчүүдийн боловсролын түвшин, хүүхдэдээ аливааг сургах аргагүй, хандлагаас ихээхэн хамаардгаараа онцлог билээ.

Хөтөлбөр эхэлмэгц эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ажиллах 8 хүртэлх цагийн сургалтад сууж, зөвлөгөө авдаг хэдий ч бие даан хэрэгжүүлэх үед туршлага, чадвар дутах нь нийтлэг байдаг. Чиглүүлэгч багш нар утсаар ярих, гэрийн эргэлт хийх замаар зөвлөн тусалдаг ч нэг нутаг усны малчид харилцан бие биеэсээ суралцах нь илүү үр дүнтэй юм. Энэхүү аргыг хэрэгжүүлэхэд хөрөнгө зардал бага гарах бөгөөд багийн засаг даргын болон чиглүүлэгч багш нарын дэмжлэгтэйгээр харилцан мэдээлэл солилцох бүрэн боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: 5 настай хүүхдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэхдээ айл саахалтаараа, ойролцоо нутгаараа “Сурвалжлагч шувуухай” дэвтэр аялуулан, эцэг эхчүүд болон хүүхдүүд бие биеэсээ харилцан суралцах бүрэн боломжтой.

СУРГАМЖ: Сурвалжлагч шувуухай дэвтрээ нэг айлаас нөгөөд шилжүүлэхдээ чиглүүлэгч багшдаа утсаар хэлж хэвших хэрэгтэй. Сурвалжлагч шувуухайны олж ирсэн мэдээллийг хуваалцах, нийтэд түгээх ажлыг ОНБЗ хариуцан гүйцэтгэж, үр дүнг тооцож ажиллах хэрэгтэй.



Сайн туршлага: **ЯРИАНЫ СХЕМ** Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМ**

АГУУЛГА: СӨБ-ын багш Д.Долгор 5 настай хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ярианы схем нэртэй аргачлалыг санаачлан хэрэгжүүлсэн нь их үр дүнтэй байна. 5 настай хүүхдийг гэр бүлийн орчинд сургуульд амжилттай бэлтгэхийн тулд хамгийн түрүүнд эцэг эхийн боловсролыг дээшлүүлэх, ном, тоглоомтой зөв харьцахыг аав ээжид нь зааж сургах нь чухал юм. Энэхүү хэрэгцээнд тулгуурлан Долгор багш багцад байгаа үлгэрийн номыг уншиж өгөөд эмх цэгцтэй яриулж сургахад дөхөм болох ярианы схемийн аргыг боловсруулсан юм. Зурган схемийг хүүхдэд ойр зүйлүүдээр дүрслэн томоор үзүүлэн хийж бэлдэх ба түүний дагуу хүүхдийг эмх замбараатай дараалуулан яриулахад сургана. Энэ аргыг хэрэглэснээр хүүхдийн хэл яриа хөгжихөөс

гадна эмх цэгцтэй ярьж сурдаг давуу талтай юм. Мөн амьдрах орчин, хоол тэжээл, хөдөлгөөн, өнгө, хэмжээ, хэлбэр дүрс зэрэг хүүхдэд хамгийн ойр байдаг зүйлсийг таниулдаг. Хүүхэд үзүүлэнгээ хараад үлгэрийн номынхоо гол баатрыг хаана амьдардаг, юу иддэг, яаж хөдөлдөг, ямар өнгө зүстэй, ямар хэмжээтэй зэргийг бүтэн өгүүлбэрээр ярьж сурдаг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Энэхүү энгийн арга нь хүүхдийн бие даан ярьж сурах чадварыг хөгжүүлдэг ба ярианы баялаг нэмэгдэж бүтэн өгүүлбэрээр ярьж сурахад дэмжлэг болно. Мөн хүүхэд нээлттэй болж, өөрийгөө илэрхийлэх чадварт суралцдаг. Энэ аргыг сурагч багш нар хэрэглэх болсон бөгөөд хүүхдээ ирээд багцаа солихоор ирэхэд нь ярианы схемийн аргаа ашиглан яриулж, үлгэрээ хэрхэн ойлгож авсныг шалгах төдийгүй эцэг эхчүүдийг хэрхэн хүүхэдтэйгээ ажилласныг бас дүгнэж, тэдэнд зөвлөгөө өгөхөд нэмэр болдог юм. Эцэг эхчүүдэд схем бэлтгэн өгч явуулснаар эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ажиллаж сурах арга барилд давхар суралцах үр дүнтэй.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Гарын доорх материал ашиглан хийдэг тул хөрөнгө шаардахгүй бөгөөд СӨБ-ын багш нар, бага ангийн багш нар, эцэг эхчүүд өөрсдөө хийх бүрэн боломжтой. Өөр өөр сэдвүүдээр баяжуулан олон схем хийж эцэг эхчүүд, багш нар өөр хоорондоо солилцон хэрэглэвэл илүү үр дүнтэй болно.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Эцэг эхчүүд ашиглаад сурчихвал цаашдаа хүүхэд нь сургуульд орох үед хүүхдүүдтэйгээ хамтарч зурж, хайчлан өөрсдөө ярианы схемээ бэлтгэн хүүхдийнхээ унших дуртай үлгэрийн ном, зохиолоор баяжуулан ашиглах давуу талтай. СӨБ-ын багш нар, бага ангийн багш нар үзүүлэн маягаар хийж хичээлдээ ашиглах бүрэн боломжтой.

СУРГАМЖ: Хийсэн схемүүдээ багш нар баяжуулан хоорондоо солилцон хэрэглэж хэвшсэн бол ярианы схемийн бүхэл бүтэн сантай болж, багш нар санал бодлоо солилцон илүү сайжруулан, илүү олон хүүхдэд түгээх боломжтой байлаа. Хийх материалаа зөв сонгож, удаан эдлэх талаас нь гарын ая даахаар хийх хэрэгтэй.

Сайн туршлага: ЭЦЭГ ЭХИЙН ДЭМЖИХ БҮЛЭГ

Хэрэгжүүлэгч: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМ



АГУУЛГА: ГБОСБХ-ийн хүрээнд эцэг эхчүүдэд гэрийн орчинд өөрийн хүүхдийг сургах орчинг бүрдүүлж өгөх шаардлага гарч ирсэн. Эцэг эхчүүд өөрсдийн нөөцөндөө тулгуурлан хүүхдэдээ сургалтын орчинг бүрдүүлэх нь боловсролынх нь түвшингээс шалтгаалан харилцан адилгүй байсан учраас хооронд нь туршлага солилцуулах, бие биеэс нь суралцуулах зорилготойгоор “Эцэг эхийн дэмжих бүлэг” байгуулсан юм. Энэ дэмжих бүлэг нь МНӨ-ний багцыг шинэ ном, тоглоомоор баяжуулах ажлыг өрнүүлсэн бөгөөд 2016-2017 оны хичээлийн жилийн нээлтэд 1-р ангид орсон Г.Бумчин, П.Анужингийн ээжүүд МНӨ-нд 100 буудалт даам, Долоодой тоглоом, Монгол ардын үлгэрийн цувралууд зэрэг ном, тоглоомуудыг хандивласан байна.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ГБОСБХ-т хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхийн дэмжих бүлэг байгуулагдсанаар ОНБЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд өөрсдийн санаачилгаар оролцож, ном, тоглоомын багц солилцох үед хүүхдийн юу сурч мэдсэнийг шалган дараагийн багцыг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг хариуцан зохион байгуулдаг болсон. Мөн ном, тоглоомын багцыг ариутган цэвэрлэж өгдөг ба идэвхтэй эцэг эхчүүд бусад эцэг эхчүүддээ үлгэр дууриал болж, ээж аавуудын оролцоо ижил түвшинд очиход дэмжлэг болсон. Багцаа солих гээд ирэхдээ эцэг эхийн дэмжих бүлгийн эцэг эхчүүд хэрхэн хүүхэдтэйгээ ажилласан туршлагаасаа хуваалцаж, хүүхдийнхээ сурах орчинг өөрсдөө бүрдүүлж өгсөн талаар бусад эцэг эхэд зөвлөгөө өгч ажилладаг. Мөн багцад шинэ ном, тоглоом хандивлах ажлуудыг өрнүүлснээр бусад эцэг эхэд үлгэр дууриал болж дараа дараагийн багцуудаа сэлбэх ном, тоглоомтой болох замыг нээж өгсөн үр дүнтэй ажил болсон. Эцэг эхчүүд гэртээ хүүхдүүдтэйгээ ажиллах цагийн хуваарь гаргадаг бөгөөд хүүхдүүд цагийн хуваарийн дагуу гэртээ тохижуулсан тохилог сургалтын орчинд ээж, аавтайгаа суралцах боломж бүрдэж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Эцэг эхчүүд өөрсдөө идэвх санаачилгатай байвал хэрэгжих бүрэн боломжтой. Хүүхдийнхээ боловсролд анхаардаг эцэг эхчүүд санаачилга гарган хүүхэдтэйгээ ажиллахад энэхүү дэмжих бүлэг их дэмжлэг болох болно. Улмаар хүүхдийн бүтээлийн үзэсгэлэнг тогтмол гарган хөтөлбөрийн үр дүнг иргэдэд нээлттэй сурталчлах боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Хүүхдийн сурах орчин бүрдсэнээр байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжоор хангагдсан ба багш сурагчид, эцэг эхийн хамтын ажиллагааны орчинг бүрдүүлбэл бүтээл хийх, шинэ сургалтын материал бэлтгэх үйл ажиллагаа тасралтгүй явагдах боломжтой. Үүний үр дүнд хүүхдийн сурах орчны материаллаг бааз байнга нэмэгдэж, шинэчлэгдэж байна.

СУРГАМЖ: Хөтөлбөрт хамрагдаж байгаа зарим гэр бүлийн амьжиргааны түвшин доогуур учраас хүүхдэдээ сургалтын орчин бүрдүүлэх боломж харилцан адилгүй байдгийг анхаарах хэрэгтэй.



Сайн туршлага: **ЮМХНААР ЮМ ХИЙЕ**
Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
БҮРД СУМ

АГУУЛГА: ГБОСБХ-өөр хичээллэж байгаа 5 настай хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэхийн тулд хэрэглэхээргүй болсон, хаях гэж байгаа эд зүйлс ашиглан хичээлийн хэрэглэгдэхүүн хийж болох талаар эцэг эхчүүдэд ойлгуулж хамтарч ажилласан. Түүнчлэн ГБОСБХ-ийн чиглүүлэгч багш, бага ангийн багш, СӨБ-ын багш, дотуур байрын багш нарын хамтын ажиллагаа сайжирч, залгамж холбоотой ажиллахад дэмжлэг болсон.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ГБОСБХ-өөр бэлтгэгдэн нэгдүгээр ангид элсэн орсон хүүхэд бүр тооны бүтцийг тодорхойлох, зураг эвлүүлэх, sudoku бөглөх, савхаар янз бүрийн дүрс хийж тоолох зэргийг маш хурдан хийж чаддаг болж, сэтгэн бодох чадвар сайжирч байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Сургалтын аргазүйн хувьд эцэг эхчүүд хүүхдэдээ хичээлийг зааж өгч, зарим үед хүүхдээсээ суралцаж байгаагаараа шинэ хандлагатай болж, багш нар нь чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэж, хэрэглэгдэхүүнийг эцэг эхчүүд өөрсдөө бэлтгэдгээрээ онцлог юм. Мөн хэрэглэхгүй болсон хаягдал материал ашигладаг учир хүндрэлтэй зүйл байдаггүй. Тухайлбал дууссан зургийн дэвтрийн хавтсыг ламинатордаад янз бүрийн дүрс болгон хайчилж, буцаагаад эвлүүлдэг тоглоом хийх гэх мэтээр янз бүрийн тоглоом хийж болдог.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом хийхдээ хүүхдүүдийн сонирхолд нийцэх сонирхолтой тоглоомыг сонгон авах хэрэгтэй байдаг. МНӨ болон дотуур байрын ХХТ-ын үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулж, аялуулан, аль болох сонирхлыг нь татсан сэтгэхүй хөгжүүлэх тоглоомоор тоглуулж сэтгэхгүйг нь хөгжүүлнэ. Энэ аргазүй нь хүүхдийн суурь хөгжлийг дэмжиж, сурлагын чанарт шууд нөлөөлдөг тул багш нар хэрэглэх боломжтой бөгөөд багш нарын хоорондын, сургууль, эцэг эх, хүүхдийн хамтын ажиллагаа сайжирдаг.

СУРГАМЖ: Хийсэн эвлүүлдэг, зурагтай сэтгэхүйн тоглоомуудаа багш нар баяжуулан хоорондоо солилцон хэрэглэж, бүхэл бүтэн сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын сантай болж, багш нар санал бодлоо солилцон илүү сайжруулж, илүү олон хүүхдэд түгээх боломж байсан. Хийх материалаа зөв сонгож, эдэлгээ, сонирхолтой байдал зэрэгт анхаарах хэрэгтэй. Эвлүүлдэг зургийг ламинатордаж хэрэглэвэл илүү удаан хэрэглэнэ.

Сайн туршлага: **12 ЖИЛ ТОГТООЛГОХ
АРГАЧЛАЛ**

Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗҮҮНБАЯН-УЛААН СУМ**



АГУУЛГА: 12 жил чээжлүүлэх, зүг чиг тогтоох энгийн аргачлалаар хэрэглэгдэхүүн хийж, МНӨ-ний багцыг баяжуулдаг. 12 жилийг цаасан дээр дугуй хэлбэрт оруулаад, дунд нь хүүхдэд зураг зурах зай үлдээгээд ламинатордана. Хүүхэд 12 жилийн голд нь гэр бүлийн гишүүдээ зураад хэн нь ямар жилтэйг 12 жил рүү зураасаар холбож өгнө. Ингэснээрээ хүүхэд аав ээж, ах эгч, дүү нь ямар жилтэйг мэдэж авах төдийгүй 12 жилээ хурдан тогтоодог.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ГБОСБХ-ийн эхэнд хүүхдүүдээс 12 жил мэдэх үү гэсэн гарааны үнэлгээний асуултыг асуухад мэдэхгүй хүүхэд олон байсан бол эцсийн үнэлгээ авч энэ асуултаар эргэн асуухад хүүхдүүд 12 жил болон зүг чигээ маш сайн тогтоосон байдаг.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Маш энгийн гарын доорх материалаар хийгддэг. Хэрэглэхэд хялбар, ойлгомжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: СӨБ-ын багш нар, эцэг эхчүүд өөрсдөө ч хийгээд ашиглаж болно.

СУРГАМЖ: Эцэг эхчүүдээр нь өөрсдөөр нь 12 жил болон зүг чигийг зуруулж хийлгэвэл эцэг эхийн оролцоо нэмэгдэж, хүүхдэдээ цаг гаргаж сурах сайн талтай.



Сайн туршлага: **ҮЛГЭРЭЭР ДАМЖУУЛЖ ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**
Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН САНТ СУМ**

АГУУЛГА: ГБОСБХ-ийн хүрээнд үлгэрээр дамжуулан хүүхдийн хэл яриа, харилцаа, бүтээлч илэрхийллийн чадварыг хөгжүүлж, хүүхэд бүрийг шинэ орчинд дасан зохицож, сурлагын хоцрогдол гаргахгүй байхад анхаарч ажилладаг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ГБОСБХ-өөр бэлтгэгдэн нэгдүгээр ангид элсэн орсон хүүхэд бүр 3-10 үлгэр мэддэг болж, ойлгон ярих чадвар сайжирч, үлгэрт дурлаж, ном унших сэдэлтэй болсон байдаг.

Дөнгөж сургуулийн сурагч болсон зарим нэг сурах идэвх муу хүүхдүүд үлгэрийн дүрд тоглохдоо маш их баяр жаргалтай болж, улмаар сурах идэвх нь шууд нэмэгдэж байв. Үлгэрийн дүрд тоглосны дараа хүүхдүүдийн сурах идэвх нэмэгдэж, ОНБЗ-ийн өрөөгөөр байнга инээмсэглэн шагайж, “багш аа” гэж дууддаг ба энэ нь шинэ орчинд хурдан дасах боломжийг бүрдүүлдэг.

Үг чээжлүүлэх, баг хийх, дүр бүтээх гээд ОНБЗ-ийн гишүүд, чиглүүлэгч багш, эцэг эхчүүд хамтран ажиллаж, хүүхдийн хөгжил, сурах үйлд гар бие оролцсон нь үр дүнтэй ажлын эхлэл болж чадсан юм. ГБОСБХ-өөр хичээллэн сургуульд орсон хүүхдүүдэд энэхүү аргыг ХБЦНХ-тэй холбон хэрэгжүүлснээр сурлагаар хоцрогдохгүй, шинэ орчиндоо хурдан дасаж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Гарааны үнэлгээг заавал хийх ёстой бөгөөд анхандаа хүүхдүүд зөвхөн нэг л үлгэрийг хагас дутуу мэддэг, асуулт тавьж чаддаггүй, бүрэг ичимхий, дуу султай, өөртөө итгэлгүй байсан учраас хүүхдийн ярих, тогтоох, жүжиглэх чадварыг хөгжүүлэх зорилгоор энэ аргагүйг боловсруулсан юм.


I үе шат: Хүүхдүүдээс 5 асуулга бүхий ярих чадварын судалгаа авч гарааг тогтооно. Энэ нь хүүхдэд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хянаж, дүгнэхэд тустай. Ном, тоглоомын багцыг ашиглан 3-7 дүр бүхий үйл явдалтай 4 төрлийн үлгэрийн ном сонгон авч, хүүхдүүддээ 1 үлгэрийг 3-аас доошгүй удаа уран яруу, төлөөлөн уншиж өгөх даалгавар өгнө. Сурсан үлгэрээ аав ээж, дүү нартаа ярьж өгөх зэргээр бүрэн сурч, өөртөө итгэлтэй болсны дараа ном, тоглоомын багцаа солилцохдоо бусад хүүхдэд ярьж өгөх, бусдад асуулт тавих зэргээр харилцан ярилцана. МНӨ-гөөр үйлчлүүлж, багц солих бүрт энэ үйл ажиллагааг улам өргөжүүлэн тогтмол зохион байгуулна.

II үе шат: ГБОСБХ-өөр хичээллэн ЕБС-ийн нэгдүгээр ангид элссэн бүх хүүхдээс үлгэрээ хэрхэн ойлгож, ярьж сурсныг нь үнэлж, хүүхэд нэг бүрт гарсан ахицыг тодорхойлно. Хүүхдүүдийн хамгийн сайн ойлгосон 5 үлгэрийг сонгон авч, дүрүүдийг хуваарилан, үгийг нь бичиж, чээжлүүлэх даалгаврыг эцэг эхэд 1-р улирлын амралтаар 14 хоногийн хугацаатай өгнө. Чиглүүлэгч багш улирлын амралтаар дүрийн багийг бэлтгэн, хүүхдүүдээс үгээ тогтоосныг нь шалган чээжлүүлэх, уран тод хэлүүлэх, жүжиглэж үлгэрээ амилуулах сургуулилалтыг 14 хоногийн турш эцэг эхтэйгээ хамтран хийснээр үлгэрээ амилуулна. “Царцаа Намжил”, “Манжин”, “Долоон өндөгтэй доголон шаазгай”, “Уутат бор”, “Эвтэй 4 амьтан” гэсэн үлгэрүүдийг амилуулан эцэг эх, хүүхдүүдэд тоглож үзүүлэн, сурсан мэдсэнээ тайлагнасан.

ОНБЗ-ийн гишүүд үнэлгээ хийх, бичлэг хийх, зураг авах зэргээр үйл ажиллагааг баримтжуулан зурагт самбарт гарган сурталчилсан.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Үлгэр нь үйл явдал ихтэй, сонирхолтой байх хэрэгтэй байдаг. МНӨ болон дотуур байрын ХХТ-ын үлгэр, номыг ашиглан хүүхдүүдээр уншуулах, дүрийн тоглолт хийх бүрэн боломжтой бөгөөд дүрээ амилуулан тоглуулах явцад тогтоох, жүжиглэх, хамтран ажиллах, өөртөө итгэлтэй болох дадал суудаг. Энэ аргагүйгээр хүүхдийн суурь хөгжлийн чадварууд нэмэгдэж, сурлагын чанарт шууд нөлөөлдөг тул багш нар хэрэглэх боломжтой.

СУРГАМЖ: Хүүхдүүд жүжиглэх, тоглох дуртай байдаг тул яаруулалгүй нэг үлгэрийг сайн тогтоолгож, яриулж сургасны дараа дараагийн үлгэрийг сургах хэрэгтэй. Эцэг эхийн хандлага, оролцоог сайжруулж, сайн ойлгуулсан байвал үр дүн илүү байна.



Сайн туршлага: **ДААЛГАВРЫН ДЭВТЭР** Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАРАГТ СУМ**

АГУУЛГА: ГБОСБХ-т хамрагдаж байгаа хүүхдэд гарах үр дүн нь эцэг эхчүүдийн боловсролын түвшин, хүүхэдтэй ажиллах аргазүй, хандлагаас ихээхэн шалтгаалдаг. Иймд эцэг эх, хүүхдийг хамтад нь хөгжүүлэх, үнэлэх, урамшуулах, идэвхжүүлэх зорилгоор “Даалгаврын дэвтэр”-ийг гаргасан юм. Энэхүү дэвтэр нь багц ашиглалтын үр дүнг сайжруулж, багийн дарга болон сум, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэн, эцэг эхийн оролцоог сайжруулж, хүүхэдтэй нь хамт хөгжүүлэн, боловсролд хандах хандлагыг нь өөрчилнө.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Энэ аргаар 5 настай хүүхдийн ярих, чээжлэх, номоос ойлгосноо зурах, бичих чадварыг хөгжүүлж байгаа ба тухайн чадваруудаа бусдаар үнэлүүлж байгаа нь хүүхдэд сурах

эрмэлзлэлийг илүү ихээр төрүүлж, эцэг эхийн оролцоог идэвхжүүлдэг. Эцэг эхчүүд багц солихдоо хүүхдээ дагуулж ирэх боломжгүй (цаг агаарын хүндрэл) үед хүүхдийнхээ сурсан, мэдсэн зүйлийг утсаар бичлэг хийн авчирч үзүүлэн, өөрсдийгөө болон хүүхдээ үнэлүүлж, түүндээ урамшин өөрсдөө ч хүүхэдтэйгээ хамтран хөгжиж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: 10 багцад тохирсон даалгавар дасгал бүхий материал бэлтгэн, сургуулийн боломж нөхцөлийг ашиглан өнгөтөөр хэвлэж, багц бүрт нэмэлтээр тараан өгч ашиглаж байна. Цаашид 5 настай хүүхдийн онцлогт тохирсон, гэрийн орчинд аав, ээжийнхээ тусламжтайгаар ярих, бичих, бодох, зурах, чээжлэх чадварыг сайжруулахад чиглэсэн дасгал, даалгавар бэлтгэн хөгжүүлэх бүрэн боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: 2014 онд оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, үлгэр бэлтгэн багцад нэмэлтээр хийж эхэлсэн бөгөөд 2016 оноос хүүхдийн бичих, ярих чадварыг илүүтэй хөгжүүлэх, орон нутгийн оролцоо, эцэг эхийн хандлагыг өөрчлөх зорилгоор багц бүрт тохирсон даалгавар дасгал, шүлэг, оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав зэргийг багтаасан засаг дарга, багийн дарга, чиглүүлэгч багш болон бусад хүмүүсээр үнэлүүлэх үнэлгээний хуудсыг нэмэлтээр оруулан эцэг эхчүүдээр хөтлүүлж хэвшээд байна.

СУРГАМЖ: Хүмүүсийн боловсролын үйлчилгээнд хандах хандлагыг өөрчилж, тэдний оролцоог нэмэгдүүлэхдээ сум, багийн засаг дарга нартай ойр хамтран ажиллах хэрэгтэй.

Сайн туршлага: ХУРУУН ХҮҮХЭЛДЭЙ Хэрэгжүүлэгч: СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМ



АГУУЛГА: Гэр бүлийн орчинд гар доорх материалаар хуруун хүүхэлдэй хийх бүтээлч үйлээр дамжуулан 5 настай хүүхдийн хэл яриа, сэтгэхүйг хөгжүүлэх, эцэг эхчүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулдаг. Хуруун хүүхэлдэй хийх, баатруудыг амилуулах сургалт, зөвлөн туслах ажлыг сумын ГБОСБХ-ийн чиглүүлэгч багш, сургуулийн номын санч нар удирдан явуулдаг. Эхний удаа эцэг эхчүүдийг сумын төвд урин гар доорх хаягдал материалыг ашиглан хуруун хүүхэлдэй хийх аргазүйн зөвлөгөө өгч, эсгүүр гаргаж өгөн, хүүхэлдэйгээ гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран оёж дуусгах даалгавар өгдөг. 2 дахь удаагийн сургалт, зөвлөгөөг чиглүүлэгч багш, ОНБЗ-ийн гишүүд гэрийн эргэлтээр очих явцдаа хүүхэлдэйгээ хэрхэн оёсон, хэрхэн жүжиглэн тоглож байгаад зөвлөн тусалдаг. Хүүхэдтэйгээ жүжигчилсэн тоглолт хийх явцад

хүүхдэд нь ямар ахиц өөрчлөлт гарч байгаа талаар ярилцаж, хүүхдэдээ цаг гарган ажиллаж байгаа гэр бүлийг урмын үгээр урамшуулдаг. 3 дахь удаагийн уулзалтаар сумын төвийн шинэ жил, хүүхдийн баяр, үр дүнгийн баяр зэрэг тэмдэглэлт өдрийг тохиолдуулан гэр бүлээр нь урьж, хийсэн бүтээсэн зүйлээр нь үзэсгэлэн гарган, гэр бүлийн жүжигчилсэн тоглолтыг олон нийтэд үзүүлдэг.

Хуруун хүүхэлдэйг хийхэд даавууны өөдөс, товч, зүү, утас, хайч, цавуу гэх мэт ахуйн энгийн зүйлс ордог учраас ямар нэгэн зардал гарахгүй, хүүхдийнхээ тоглоомыг баяжуулж өгч байгаадаа баяртай байгаа талаар эцэг эхчүүд хэлдэг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Хуруун хүүхэлдэй хийж, үлгэрийн баатруудыг амилуулснаар хүүхдийн хувьд тоглоом тоглохоос илүү номоо уншуулах дуртай болсон, ярих, сэтгэх чадвар хөгжсөн, шүлэг амархан чээжилдэг болсон, нүүрэмгий, өөртөө итгэлтэй байдал нэмэгдсэн. Харин эцэг эхчүүдийн хувьд гар доорх материал ашиглан бүтээл хийх талаар мэдлэгтэй болж, хүүхэдтэйгээ хамтран ажиллах эв дүй сайжирч, бүтээлч байдлаар хүүхдээ хөгжүүлж болдгийг ойлгосон. Гэр бүлийн харилцаа хамтын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж алдаа гаргасан ч түүнийгээ засах боломжтойгоо ойлгоход сайн дэмжлэг болдог.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Хуучин, хэрэглэдэггүй даавуу, материалын өөдөс, товч, кноп ашиглах боломжтой. Мөн бусад эцэг эхчүүдийн хийсэн хуруун хүүхэлдэйг хоорондоо солилцон ашиглах боломжтой. Зай талбай, үнэ өртөг шаардагдахгүй. Бага насны хүүхдийн сонирхлыг татахуйц, ашиглахад хялбар, гарт эвтэйхэн хийх нь чухал. Хүүхдийн хэл яриа сайн хөгжиж байвал заавал ном харах шаардлагагүй, гэр бүлээрээ, хүүхдээрээ бие даан үлгэр зохион, зуруулах, баатруудыг хүүхэдтэйгээ хамтарч хийх, тоглох зэрэг бүхий л талаар хүүхдийг хөгжүүлэх боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Сургуулийн номын санч МНӨ-г хариуцан ажилладаг ба жил бүрийн ГБОСБХ-т хамрагдаж буй хүүхдүүдийн эцэг эхчүүдээр бүтээл хийлгэх боломжтой. Мөн МНӨ-нд байгаа хуруун хүүхэлдэйг гэр бүлд нь өгч явуулах, эцэг эхчүүдийг гэртээ хийх сэдлийг төрүүлэх ажлыг зохион байгуулна.

СУРГАМЖ: Хуруун хүүхэлдэйг хийх зөвлөмжийг эцэг эхчүүдэд өгөх, хүүхдээр чадах зүйлийг нь хийлгүүлэх, бие даан үлгэр зохиолгон зуруулах, гэр бүлийн тоглолтыг байнга хийлгэж байх нь зүйтэй.



Сайн туршлага: **БАРИМЛЫН ШАВРЫГ АМИЛУУЛЪЯ**
Хэрэгжүүлэгч: **СҮХБААТАР АЙМГИЙН
МӨНХХААН СУМ**

АГУУЛГА: Мөнххаан сумын ОНБЗ ГБОСБХ-т хамрагдаж буй хүүхдүүдийн эцэг эхчүүдийг улирал тутам чадавхжуулах сургалтыг танхимаар зохион байгуулдаг. Эдгээр сургалтын нэг нь 3D баримлын шавраар бүтээл хийх аргачлал юм. 3D баримлын шавраар бүтээл хийх аргачлал бүхий зурагт гарын авлагыг бэлтгэн ном, тоглоомын багцад хийн явуулдаг. Эцэг эхчүүд ямар ч багц авсан баримлын шавраар бүтээл хийх гарын авлага байдаг тул олон төрлийн бүтээлийг гэр бүлийн гишүүд хамтдаа хийж байна. Чиглүүлэгч багш нар гарын авлагаас бүтээлээ хэрхэн хийж байгаа талаар утсаар болон гэрийн эргэлтээр зөвлөн туслахаар ажиллах үедээ асууж, заавар зөвлөгөөг өгдөг. 3D баримлын шавар сонгосон нь хэдийгээр энгийн мэт санагдах боловч олон давуу талыг үр шим хүртэгч өрхүүдэд өгч байна.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Бүтээл хийж, үр дүнг нь хялбар хүртэх боломж нь аливаа зүйлсийг дуустал хийж сурах зөв дадлыг хүүхдэд олгож байна. Хүүхэд хийж бүтээх явцдаа өөрийн санаа бодлыг шууд илэрхийлж, шийдэл нь таалагдаж байгаа эсэхийг хэлэх, өөрөөр оролдоод үзэх зэргээр шийдвэр гаргах чадвараа ахиулдаг. Хүүхдийн гарын шуу болон хурууны жижиг булчингууд хөгжинө. Түүнчлэн гэр бүлийн бүтээлээ тайлбарлан ярих чадвар нэмэгдсэн бөгөөд хүүхэд өөрийн сурч мэдсэн оньсого, шүлэг, үлгэрийн баатруудыг аав, ээжийн тусламжтайгаар өөрийн хэмжээнд сэтгэж хийдэг болсны дээр өнгөний мэдрэмж сайжирч, үндсэн өнгүүдийг амархан тогтоодог болсон.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: 3D баримлын шавар нь бага багаар савлагдсан байдаг тул хүссэн өнгийг өрхийн төсөвт тохируулан худалдан авах боломжтой. Амархан хатдаг тул түлхүүрийн оосор хийх, тоглоом болгон тоглох боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Эцэг эхчүүдийг чадавхжуулах сургалтад хамруулан, арга аргачлалыг зааж өгөх. Тараах материалыг бэлтгэн ном, тоглоомын багцад байрлуулах. Ном, тоглоомын багц солих үед тараах материалыг заавал танилцуулах. Баримлын шаврын зардал бага буюу 1 уут нь 800 төгрөг тул эцэг эхчүүд хүүхдэдээ авч өгөхөд санхүүгийн хүндрэл гарахгүй.

СУРГАМЖ: 3D баримлын шавар олдохгүй, үнэтэй гэсэн ташаа ойлголттой байдаг тул үнэн зөв мэдээлэл өгөх хэрэгтэй. Материалын шинж чанарын хувьд өнгө тод, агаарт амархан хатдаг төдийгүй бэлэг дурсгалын зүйл хийх боломжтойн дээр удаан хэрэглэгдэх биет материал юм. Гарт зууралдаж, наалдахгүй учир хүүхдийн сонирхлыг ихэд татдаг ба хүүхдүүд уйгагүй сууж бүтээл хийдэг. Сайхан, цэвэрхэн бүтээл хийх гэсэн хүсэл эрмэлзлээсээ болж эцэг эхчүүд хүүхдийн өөрийн хийж чадах зүйлийг урдуур нь орж хийх нь хүмүүжлийн хувьд сөрөг үр дагавартай бөгөөд хүүхдийн өөртөө итгэлтэй байдлыг бууруулдаг болохыг сайтар анхааруулах шаардлагатай.

2 ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГА





Сайн туршлага: **ААВУУДЫН ОРОЛЦОО**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН**
ӨЛЗИЙТ СУМ

АГУУЛГА: Дотуур байр болон айлд сууж байгаа хүүхдүүдийн аавуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Аавуудын өдөр”-ийг жил бүр зохион байгуулдаг. Энэ өдөр аавуудын дунд хүүхэдтэйгээ хэрхэн ажилладаг, бид яаж туслах вэ, бидний давуу тал зэрэг асуудлыг дэвшүүлэн хэлэлцүүлэг зохион байгуулдаг. Аавууд ярилцлага, хэлэлцүүлгийн дараа үйл ажиллагааг

хэдийд, яаж, хэнд хэрэгжүүлэх талаар үйл ажиллагааны төлөвлөлт боловсруулан ОНБЗ-д хүргэдэг. Үйл ажиллагааны үед аав нэг бүрийн чадварт үнэлгээ хийж, хэрэгцээтэй тал дээр нь тусалж, үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.

Жишээ нь: Аавууд нийлээд ХХТ-д ардын уламжлалт тоглоом наадгайг төрөл бүрээр тоглож сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гарын доорх материал ашиглан цаасан ширдэг, олбог хийж, шагайн бүх төрлөөр тоглох нөөц болгон шагай цуглуулж өгснөөс гадна бага ангийн багш нарт гарын авлага болгон эсгийгээр монгол гэрийн бүтцийг гаргаж, геометрийн ухагдахууныг таниулах бодит үзүүлэн, шатар, даамны дугуйланд ашиглах эсгий хөлгүүдийг нэгэн зэрэг 60 хүүхэд тоглохоор хийж олшруулан, модоор үзүүлэн бэлтгэж өгсөн.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Аавууд хүүхдэдээ цаг зарцуулах нь дадал хэвшил болж, оролцоо нь сайжирсан. Дараа жилийн аавуудын өдрөөр хийх ажлаа төлөвлөөд ирдэг болсон. Бусдад үлгэр дууриалал болж байгаа.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Аавуудад мэдээлэл сайн өгөх, өмнөх гарсан үр дүн, туршлагуудыг баримтжуулан түгээх хэрэгтэй. Бусад аавуудад нөлөөлж чадах хүмүүсийн судалгааг урьдчилан гаргаж төлөвлөх, бодит үр дүнг гаргаж үйл ажиллагаа зохион байгуулах нь зүйтэй.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Жил бүр уламжлал болгон 3-р сард зохион байгуулж хэвшсэн. Аавуудын зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Онцлох үйл ажиллагаа зохион байгуулсан аавыг урамшуулан, фото зургийг сургуулийн сонин, самбар, буланд алдаршуулдаг.

СУРГАМЖ: Хамгийн анхны үйл ажиллагаа, үр дүн сайн байх хэрэгтэй. Заавал үр дүнг шууд хүртсэн, мэдрэгдсэн бодит, бүтээлч ажил санаачлан хийсэн байх нь чухал.

Сайн туршлага: **ЦААСАН ХУЙМАЛ**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН**
ХАЙРХАН СУМ

АГУУЛГА: Бусдаас өвөрмөц байж, хөдөө орон нутагт хэрэгжүүлж болох шинэлэг зүйлийг эрэлхийлэн багш өөрөө цаасан хуймал хийх аргад суралцаж ирээд, ХХТ-ыг түшиглэн дотуур байранд болон айлд суудаг бага ангийн хүүхдүүдэд дугуйлан хичээллүүлсэн. Багш ганцаараа хүүхдүүдтэй ажиллалгүй эцэг эхчүүдтэй хамтардаг. Хийх бүтээлийн сэдвээ хүүхдүүд өөрсдөө гэртээ зохиомжлон ирж, эцэг эхчүүд хамтран хийнэ. Энэ үед хүүхдүүд эцэг эхдээ ерөнхий зааварчилгааг өгөх ба эцэг эхийн хувьд хүүхдүүдээ цавуугаа цэвэр нямбай, зөв түрхэх, сальфетка хэрэглэх, өнгө хоршуулах зэрэгт тусална. Хүүхдүүд өөрсдийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж түүгээрээ бахархаж, тэмдэглэлт өдрүүдээр өөрсдийн дотны хүмүүстээ бэлэг барьдаг болсон. Анги болон сургуулийн коридорт сурагчдын цаасан хуймлын бүтээлээр бахархан байршуулсан булантай болсон.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Анги удирдсан багш, эцэг эхчүүдээс хүүхдийн хичээл сургалтын явцад гарсан өөрчлөлтийг санал асуулгаар авахад хүүхдүүдийн хийсэн бүтээлийг үзээд сэтгэл дүүрэн байна, багш нарын хувьд хүүхдүүд хичээл тасалдаггүй, хичээлдээ дуртай болж, анхаарлын түвшин маш сайн нэмэгдэж байна гэсэн үнэлгээг өгсөн. Хүүхдийн гарын ур дүй хөгжиж, зохиомжлох чадвар дээшилж, санаачилгатай болж, бусдадаа үлгэрлэж, цэвэрч нямбай болж байна. Цаасан хуймлаар хүүхдийг хөгжүүлэхэд хүүхэд бүрийн багаар хамтран ажиллах, анхаарал тогтвортой болох, сууж сурах, аливаад шийдвэр гаргах, өнгөний зохицол болон зохиомж хийх чадвар нэмэгддэг. Хүүхдийг бүтээлээр нь ахиц, амжилтыг тооцон үнэлэхэд маш хялбархан. Өөрөө өөрсдийгөө үнэлж дүгнэдэг, бие биеэсээ суралцдаг гээд маш олон чадвар эзэмшдэг.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ХХТ-ыг түшиглэн хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх зорилгоор багш, эцэг эх, сайн дурын ажилтан гээд нямбай, бүтээлч сэтгэлгээтэй хэн бүхэн хичээллүүлэх боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Цаасан хуймлыг хийж сурсан хүүхдүүд бусад хүүхдүүдэд зааж өгөн бага ангийн хүүхдүүд суралцаад байна. Хүүхэд хүүхдээсээ илүү сайн суралцаж байна.

СУРГАМЖ: Сонирхлыг нь сайн судалж үзэх хэрэгтэй.





Сайн туршлага: **ИЛТГЭЛИЙН ИНДЭР**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН**
ХОТОНТ СУМ

АГУУЛГА: ХХТ-аар үйлчлүүлдэг хүүхдүүдээр ном уншуулан, “Уншсан номын сэтгэгдлээ хуваалцах өдөр”-ийг зохион байгуулж, төрсөн сэтгэгдлээр илтгэл тавиулах зорилгоор индэр хийсэн бөгөөд энэ үйл ажиллагаагаараа хэрхэн олны өмнө ярихыг зааж өгдөг. “Гэрэлт алсын цацраг” нэртэй илтгэлийн уралдааныг тогтмол зарлаж, зорилтот хүүхдүүдээр илтгэл тавиулдаг тул индрээ ийнхүү нэрлэсэн бөгөөд ХХТ-аар үйлчлүүлдэг бүх хүүхдийг хамруулан, тэдэнд тэгш боломж олгодог.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Хүүхдүүд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөртөө итгэх, харилцах чадвар нь хөгждөг. Оролцсон хүүхдүүд урам авч дараа дараагийн уралдаанд чадвар нь нэмэгдсэн байдаг. Хүүхдүүдийн ном унших сонирхол нэмэгдэж, уншихдаа ойлгож, ач холбогдол өгч уншдаг болдог.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Илтгэлийн сэдвийг өөрчлөн хүүхдүүдийн сонирхолд тулгуурлан хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Индрийг хийхдээ хөдөлмөрийн багш нарт хүсэлт тавин, ахлах ангийн хүүхдүүдээр хөдөлмөрийн хичээл дээр хийлгэж болно.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: ХХТ-ын номын баяжилтыг тогтмол хийх хэрэгтэй. Уг илтгэлийн уралдааныг ХХТ-ын нэрэмжит арга хэмжээ болгон, сургуулийн хэмжээнд уламжлалт ажил болгон зохион байгуулна.

СУРГАМЖ: Илтгэлийг чанартай бичүүлэхийн тулд бэлтгэх хугацааг урт байлгах хэрэгтэй.

Сайн туршлага: ХҮҮХЭД НЭГ БҮРИЙН АХИЦЫН ҮНЭЛГЭЭ

Хэрэгжүүлэгч: АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМ



АГУУЛГА: ХХТ-аар үйлчлүүлж буй хүүхэд нэг бүрийн Монгол хэл, Математикийн хичээлээр гаргаж байгаа үр дүн, ахицыг улирал бүр хүүхэд нэг бүрийн чадвараар, анги тус бүрээр (1а, 1б, 2а гэх мэт), бүлэг тус бүрээр (1-р ангиуд, 2-р ангиуд гэх мэт) харьцуулан гаргаж, анги удирдсан багш нараар сурлагын байдалд дүгнэлт бичүүлэн, бүтээлийн хавтаст хийн ажилладаг. Хүүхдүүдийн ахиц, амжилтад дүгнэлт хийгээд, сурлагын ахиц огт гараагүй болон ахиц буурсан хүүхдүүдэд судалгаа хийж үзээд, ангийн багш нараар ахиц гаргахын тулд хэрхэн ажиллах төлөвлөгөө гаргуулан, бага ангийн заах аргын нэгдэл (БАЗАН)-ээр хэлэлцэж, төлөвлөгөөг батлан ажиллуулж байна. Судалгаагаар сурлагын ахиц гаргаж чадахгүй байгаа хүүхдүүдийн ар гэр буюу амьдардаг айлын амьдралын нөхцөл тааруу байх, ахлах ангийн олон хүүхдүүд нэг айлд амьдрах, хичээл таслах зэрэг буруу зан үйлд уруу татагдах гэх мэт шалтгаанууд илэрснийг таслан зогсоох зорилгоор сумын засаг даргад уламжилж, эцэг эхтэй нь холбоо тогтоох, хүүхдүүдийг урамшуулах олон төрлийн уралдаан тэмцээнийг Засаг даргаар шагналыг шийдвэрлүүлэн зохион байгуулах, сумын хэмжээний кампанит ажилтай уялдуулан хүүхэд, эцэг эх, сургууль, сумын удирдлагуудтай уулзалт хийлгэх зэргээр ажилласан.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Бага ангийн хүүхдүүдийн сурлагын чанар эрс сайжирч, бага ангийн багш нарын оролцоо нэмэгдсэн. Хүүхэд бүрийн ахицыг тооцож ажилласнаар багш нарын хариуцлага, оролцоо сайжирсан. Ахицын харьцуулалт, дүгнэлт хийх ажлыг бага ангийн сургалтын менежер гардан хийж хэвшсэнээр бага ангийн багш нарын заах, үнэлгээ хийх арга барил сайжирч, аймаг, бүсийн сайн хичээл заах уралдаан тэмцээнд өмнөх жилүүдээс амжилттай оролцож байна. Дотуур байранд суух бага ангийн хүүхдийн тоо ч эрс нэмэгдэж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Бага ангийн багш нарын ХХТ-д хичээллэх хуваарийг багшид ачаалал болохгүй байдлаар гаргаж, хичээлийн төлөвлөгөөнд ХБЦНХ-ийн агуулгыг оруулж өгөн ажиллах боломжтой. Хүүхдүүдэд сурлагын ахиц гарснаар тухайн анги хоцрогдолгүй болж, амжилт, чанарын ахицтай болсноор багшийн ажлын ачаалал багасаж, нэр хүнд өсдөгийг багш нар мэдрээд ХБЦНХ-төө маш дуртай болдог.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Бага ангийн сургалтын менежер багш нарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ХХТ-д хичээллэх үйл ажиллагааг тусгуулан батална. Үр дүн тооцох, урамшуулах арга замыг тодорхойлно.

СУРГАМЖ: Өмнө нь ХХТ-д дотуур байрын хоёр багш зөвхөн дугуйлан хичээллүүлэх байдлаар ажиллаж байсан нь учир дутагдалтай байв.



Сайн туршлага: **ХҮССЭН ЗҮЙЛЭЭ СУРАХ БОЛОМЖ**

Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ СУМ**

АГУУЛГА: Хүүхдийн сонирхол хэрэгцээний судалгааг авсны үндсэн дээр хүүхэд бүрийн сонирхол, чадварт тулгуурласан эсгий, шүр, цаасаар бүтээл хийх, үлгэрийн ном бүтээх, баримлын шавраар бүтээл хийх, өөрийн гараар жимсний шүүс бэлтгэх, зууш хийх аргад суралцах, цэгэн массаж хийж сурах, дүрийн тоглолт хийх, шүлэг зохиох, ХХТ-ийн

сүлд дуутай болох зэргээр давтагдахгүй үйл ажиллагааг явуулдаг. Сургуулийн удирдлага тус танхимд орон тооны багштай байх нь үр дүнтэй гэж үзэн цөөн хүүхэдтэй бага ангийг нэгтгэж нэг анги болгоод, бага ангийн нэг багшийн орон тоо гаргаснаар ХХТ-д орон тооны багштай болсон тул хүүхдүүд цагт баригдахгүй хичээллэдэг. Хүүхэд бүрийн сурлагын ахицыг дүгнэхээс гадна зан төлөвийн судалгааг хийдэг. Хүнтэй зөв боловсон харьцах, биеэ зөв авч явах, баг болж ажиллах, бусдыг сонсож сурах, хүндэтгэх, шинийг эрэлхийлэх гэх мэт чадваруудыг хүүхэд бүрт эзэмшүүлэн ажилладаг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, хийх, бүтээх хүсэл эрмэлзэлтэй болж, өөрийгөө илэрхийлэх чадварт суралцаж, аливаад хандах хандлага өөрчлөгдөж, үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэн, зөв дадал хэвшилтэй болж байна. Энэ бүхэн нь сурлагад ч сайнаар нөлөөлж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Хүүхдийн хэрэгцээ сонирхлын судалгааг зөв дүгнэж, багш өөрийн нөөц, чадварыг хөгжүүлэн ажиллах ба ХБЦНХ-ийн аргазүйг сайтар эзэмшиж, хөрвүүлэн хэрэглэх нь зүйтэй.

СУРГАМЖ: Хүүхэд дургүй зүйлдээ амжилт гаргадаггүй, харин ч урам хугарах, итгэл алдрах байдал илэрдгийг санах. Багш өөрөө хүүхдүүдийн сэтгэлд хүрч ажиллах, тэднийг сэтгэлээсээ хайрлах хэрэгтэй.

Сайн туршлага: **ХӨГЖИЛТЭЙ ДУРАН-ШИДЭТ ҮЗЭГ**

Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМ**



АГУУЛГА: Сурлагаар хоцрогдож буй хүүхдүүдийн унших, алдаагүй бичих, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх замаар тэднийг хөгжүүлж байна. ХБЦНХ-ийн Шидэт үсэг, Дуурайлган зохиох аргаас сэдэвлэн ХБЦНХ-д хамрагдаж буй хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх, сургууль дээр зохион байгуулагдаж буй үйл ажиллагааг шуурхай сурвалжлан хүүхдүүдэд мэдээлэх зорилгоор “Хөгжилтэй дуран - Шидэт үзэг” клубыг 4-5-р ангийн 10 сурагчтайгаар байгуулж, ахлах болон нарийн бичгийг өөрсдийнх нь саналаар сонгож баталсан. Клуб дотроо мэдээллийн болон зураглаачийн баг болж ажилладаг. Клубын үйл ажиллагааг дараах алхмаар явуулдаг. Үүнд:

1-р алхам: Хүүхдүүд сургууль дээр зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцон, мэдээллээ өөр хоорондоо хуваалцана. Ямар үйл ажиллагаанд оролцсон, хэн, хэн оролцсон, юу нь таалагдсан гэх мэтээр хэлэлцүүлэг өрнүүлж ярилцдаг.

2-р алхам: Хүүхдүүд мэдээллээ цаасан дээр мэдээ болгон бичиж эхэлсэн.

3-р алхам: Бичсэн мэдээлэлтэйгээ уялдуулан зураг авч хэрхэн баримтжуулах алхмуудыг хийсний үр дүнд хүүхдүүд оролцсон үйл ажиллагаагаа тайлагнан бичих чадварт суралцсан. Мөн алдаагүй бичих, сайхан бичих чадваруудыг давхар эзэмшсэн.

4-р алхам: Бичсэн мэдээлэл, авсан гэрэл зургийн мэдээллээ сургуулийн самбаруудад байршуулан мэдээлж эхэлсэн.

“Хөгжилтэй дуран - Шидэт үзэг” клубын хүүхдүүдэд алхам бүрт нийгмийн ажилтан, чиглүүлэгч багш нар зөвлөн тусалдаг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Багаар ажиллах чадварт суралцсан, ангийн болон сургуулийн үйл ажиллагаанд оролцох идэвх оролцоо нэмэгдсэн, найруулан бичих явцдаа үгийн баялгаа нэмэгдүүлж, үсгийн алдаагаа багасгах, үйл явцыг дараалалтай бичихэд бага багаар суралцсанаар Монгол хэлний хичээлдээ сайжирсан. Мөн зураг зөв авч сурах аргад суралцаж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: 1-5 дугаар ангийн хүүхдүүдийг баг болгон ажиллуулах бүрэн боломжтой. Хүүхдүүдийн хүсэл сонирхолд тулгуурлах, хүүхдүүдийн үзэж харсан зүйлийг хооронд нь яриулах, ярьсан зүйлийг бичүүлэх, бичсэн зүйлийг найруулах зэргээр зөвлөн тусалж ажиллавал хүүхдүүд бүтээлчээр сэтгэж, хөгжих бүрэн боломжтой. Зураг авах, мэдээлэл найруулан бичихээс гадна клуб дотроо “Шидэт үзгийн эзэн”, “Мэдээллийн хайгуулч” гэх мэт аян, тэмцээн зохиох боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: “Хөгжилтэй дуран - шидэт үзэг” клубын хүүхдүүд дунд ангид орох үед бага ангийн хүүхдүүдээс гишүүнээр элсүүлэн чадавхжуулан ажиллах боломжтой. Сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багш нар оролцооны бүлгийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж ажиллана. Зурагт мэдээллээс гадна “баярлалаа”, “болиоч ээ” гэх мэтээр хүүхдүүдийн анхаарлыг татах ажлуудыг зохион байгуулах чадварыг эзэмшүүлэн ажиллах боломжтой.

СУРГАМЖ: Мэдээллийг сар бүр болон аливаа үйл ажиллагаа бүрт тогтмол гаргаагүйн улмаас бусад сурагч, эцэг эх, багш нарт төдийлөн хүртээмжтэй байж чадаагүй. Шинээр үүссэн клуб учраас сурагчдын бие даан ажиллах чадвар дутмаг байсан.

Сайн туршлага: **МИНИЙ ШИРЭЭНИЙ НОМ**
Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН**
СЭРГЭЛЭН СУМ



АГУУЛГА: Бага ангийн хүүхэд бүрийг бүтээлийн сантай болгох гэж эцэг эхчүүдээс жил бүр 20, 30 хуудастай хавтас авдаг. Хавтсанд хийсэн бүтээл жилийн эцэст урагдаж алга болох зэргээр хүүхдийн хийсэн зүйл үнэгүйдэх эрсдэл их байдаг. Тэгвэл Сэргэлэн сумын бага ангийнхан ХБЦНХ-ийн сургалтын аргуудаар бүтээгдсэн өөрсдийн бүтээлээ хуучин календарьт наан өвөрмөц бүтээлийн сантай болсон.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Суралцагчийн зураг ойлгох, зурах, хийж бүтээх, өөрийн болон бусдын бүтээлийг харж, ойлгосноо ярьж тайлбарлах чадвар нэмэгдэж байна. Цаасыг эвхэх, нугалах, урах, хайчлах, наах аргыг мэдсэнээр цаасаар өөрийн сонирхсон болон ахуйд хэрэглэх жижиг зүйл урлах, бэлэг дурсгалын зүйл хийж дурсгах, дахин ашиглах аргыг эзэмшсэн. Өөрийн хийсэн бүтээлээ зохиомжлох, нэр өгч, шүлэг зохион бичих, бүтээх идэвх оролцоо, хийх гэсэн хүсэл тэмүүлэл нь хүүхдийн бүтээл болон уралдаан тэмцээнд оролцож байгаа байдал, хичээлийн үйл ажиллагаанаас тодорхой ажиглагдаж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Хуучин хэрэглэгдэхгүй ширээний болон бусад календарыг ашиглах боломжтой. Ширээний номын бүтээлийг багш сурагчид гарын авлага болгон ашиглах боломжтой бөгөөд авч явахад амар хялбар. Бага насны хүүхэд зураг ихтэй, бичвэр цөөнтэй номонд дуртай байдаг учраас хуудас болгон дээр бүтээл, өөрийн зохиосон богинохон шүлгийг оруулж өгсөн байгаа.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Багш аливаа үйлийг тодорхой зорилготойгоор хийлгээд хэвшсэн бол хүүхдийн зурах, бүтээх, чадвар нь хөгжсөнөөр анги ахих тусам унших, бичих, ярих чадварт ахиц гарч, хийх, бүтээх хүсэл сонирхол нь улам нэмэгдэж байдаг. Шууд бүтээл хийлгэхээс өмнө нь эхлээд хийх бүтээлийн тухай ярилцаж, багш өөрийн хийсэн бүтээлийг сурагчдад үзүүлж, сурагчдын сонирхлыг татан, улмаар тэдэнд бүтээл хийх сэдэл төрүүлээд, дараа нь сурагчидтайгаа хамтран хийх бүтээлийн талаар бага хэмжээний ажлын төлөвлөгөө гарган ажиллана. Сурагчдын өөрийгөө илэрхийлсэн бүтээлийг нь багш урамшуулан магтахаас гадна хэрхэн сайжруулах, аль хэсэгт нь алдсан зэргийг нь зааж зөвлөхөд сурагчид маш сайн хүлээж авдаг. Энэ нь хүүхэд алдаа гаргасан ч түүнийгээ засах боломжтойгоо ойлгоход сайн дэмжлэг болдог.

СУРГАМЖ: Хугацаа нь дууссан календарийг дахин ашиглахаас гадна бусад хаягдал материал ашиглан бүтээл хийх боломжтойг олж хараад суралцаж байна.



Сайн туршлага: **ЭЛЧ БЯЛЗУУХАЙН
ЖИРГЭЭ**

Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМ**

АГУУЛГА: Сургуулийн бага ангийн хүүхдүүд ямар нэгэн асуудал тулгарахад хаана, хэнд хандахаа мэдэхгүй тохиолдол их гардаг. Сэргэлэн суманд 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг “Элч бялзуухайн жиргээ” бүлэг үйл ажиллагаагаа явуулаад 2 жил болж байна. Уг бүлгийн гишүүд нь 1-5

дугаар ангийн дотуур байр болон айлд амьдардаг хүүхдүүд байдаг. Тэд энэ хугацаанд үе тэнгийн хүүхдүүдэд тулгамдсан 10 гаруй асуудлыг шийдвэрлэж тусалсан байна. Бүлгийн гишүүд сургуулийн бага ангийн хүүхдүүдээс “Танд тулгамдаж байгаа асуудал байна уу?” гэсэн илрүүлэх санал асуулгыг 2 сард 1 удаа явуулын микрофон болон бяцхан саналын хайрцаг аялуулан амаар болон бичгээр авдаг бөгөөд сурагчдын өгсөн саналыг бүлгийн гишүүд эрэмбэлдэг. Хамгийн их санал авсан асуудлыг тухайн холбогдох албаны хүнд албан тоотоор дамжуулан уламжилдаг. Бүлгийн албан тоотыг бүлгийн гишүүд чиглүүлэгч багштай хамтран бичдэг бөгөөд албан тоотын хариу нь зарим тохиолдолд бичгээр ирдэг.


ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Бүлэг байгуулагдан ажилласнаар:

- Бага ангийн сурагчид үзэл бодол, хүсэл сонирхол, сумын хэмжээнд буюу өөрт тулгамдаад байгаа зүйлийг амаар болон бичгээр чөлөөтэй илэрхийлэх чадварт суралцаж байна.
- Хүүхдүүд тулгамдсан асуудлаараа хаана, хэнд хандахаа мэддэг болж байна.
- Багаар ажиллах чадвар нэмэгдсэн.
- Хүүхдүүд асуудлыг эрэмбэлж сурч байна.
- Хүүхдүүд анх ичдэг байсан бол одоо өөрсдөө чөлөөтэй ярьж чаддаг болсон.
- Өөрсдийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх, насанд хүрэгчдээс тусламж авч болох талаар ойлголттой болсон.
- Бүлгийн хүүхдүүд нүүрэмгий, бие биенийхээ үгийг сайн сонсдог болсон.

ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ: Бага ангиас нь хүүхдийн оролцох эрх, оролцооны бүлгүүдийн үйл ажиллагааны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, бага ангийн хүүхдийн дэмжих бүлэг байгуулан, багаар ажиллахын ач тусыг ойлгуулах, хамтын ажиллагаанд сургах, хүүхдийн оролцооны бүлгийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, судлуулах, бага ангийн хүүхдүүдийн хамгааллын асуудалд өөрсдийн хувь нэмрийг оруулах, холбон зуучлах боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Оролцооны дэмжих бүлгүүдийг байгуулан ажиллахад нийгмийн ажилтан аргагүйгээр хангаж ажиллах, дэмжин туслах, 1-5 дугаар ангийн хүүхдүүдийн тусгай бүлгийг жил бүрэн чадавхжуулан, шинэчлэн зохион байгуулж ажиллах боломжтой. Дотуур байр болон бага, дунд, ахлах ангийн багш нар чиглүүлэгч багшаар ажиллах боломжтой. Эцэг эхийг татан оролцуулах, тэдэнд хүүхдүүдийн санал бодол, дуу хоолойг хүргэж ажиллах хэрэгтэй.

СУРГАМЖ: Бүлгийн гишүүн хүүхдүүдэд хариуцлагатай байж, бусдынхаа дуу хоолой болно гэдгийг ухамсарлуулж ойлгуулах нь чухал. Бага насны хүүхдэд урам өгөх нь чухал тул бяцхан зүйлээр урамшуулж байх хэрэгтэй. Үг, үйлдэл, хөдөлгөөн бүрийг нь зөв чиглүүлж, зөв алхам бүрийг нь магтаж сайшааж байх нь чухал. Бүлгийн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж, эцэг эх, олон нийтэд танилцуулдаг байх хэрэгтэй.





Сайн туршлага: **ТАНЫ ЦАГ**
Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН
ХАЛХГОЛ СУМ**

АГУУЛГА: Хүүхдийн хөгжил төлөвшилд насанд хүрэгчдийн оролцоо хамгийн чухал. 2015 оноос Халхгол сумын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн оролцоотойгоор дотуур байрын сурагчдын олон нийттэй харилцах харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх, тэднийг ахуй амьдралтай танилцуулах, амьдарч буй орчин нөхцөлийг сайжруулахад туслах, оюуны болон материаллаг

хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах зорилготойгоор “Таны цаг” өдөрлөгийг 7 хоног тутам зохион байгуулж хэвшсэн.

Сумын албан байгууллагын ажилтнууд, иргэд, олон нийт нь дотуур байрыг түшиглэн байгуулагдсан ХХТ-д зочилж, хүүхдүүдтэй уулзан, хөгжөөнт тэмцээн уралдаан, ажил мэргэжлийн онцлог сайхныг таниулсан үйл ажиллагаануудыг зохион байгуулахаас гадна өрөөний тохижилтод санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг санаачлан хийж, хүүхдийн төлөөх үйл ажиллагаанд идэвх оролцоо нэмэгдсээр байна. Тухайлбал:

- ЗДТГ-аас “Чанга шивнээ” хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан.
- Ахмадын хорооноос хэрчмэл цаасаар мэндчилгээ хийх болон уламжлалт хөлөгт тоглоом тоглох аргыг заан хөлөгт тоглоом хандивласан.
- Ялалт музейн хамт олон Халхголын дайны тухай, Монгол бахархал, хөшөө дурсгалт газруудын түүхэн баримттай сонирхолтой сургалтыг зохион байгуулсан.
- Сум дундын эмнэлгийн эмч нар сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаас гадна эрүүл хооллолт, ханиад, халдварт өвчнөөс сэргийлэх арга, хачиг гэж юу вэ? гэх мэт сургалт болон “Цэвэр ба бохир гар” тэмцээн зохион байгуулж урамшуулсан.
- Хилийн цэргийн 0198-р ангиас цэрэг эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор хил хамгаалах байгууллагын талаар сургалт хийж, хилчин дайчид концерт тоглож сонирхуулсан.

- Зэвсэгт хүчний 329-р ангийн ажилтнууд цэргийн хүний баримтлах дэг журам, мэргэжлийн онцлогийн талаар халуун яриа өрнүүлсэн.
- Сургуулийн захиргаанаас угаалгын машин, дэлгэц проектор, 3 үйлдэлт принтер зэрэг техник хэрэгслээр хангаснаар хүүхдүүд мэдээлэл технологийн орчинд өөрсдөө бие даан хөгжихөд нь дэмжлэг болсон. Мөн эцэг эхийн уулзалтын өрөөг тохижуулж, багш, ажилтнууд нийлж, Зан заншлын танхим байгуулж өгсөн.


ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Олон нийтийн хувьд дотуур байрын үйл ажиллагааны талаар эерэг ойлголттой болж, ХХТ-ын үйл ажиллагаатай танилцан, хүүхдүүдэд сэтгэлийн дэмжлэг үзүүлэх нь хэвшил болсон. Иргэд олон нийт хамтарч ажиллахын ач холбогдлыг ойлгож эхэлсэн. Мөн олон нийтийн сайн дурын идэвхтэй оролцоо нэмэгдэж, хүүхдүүдийн төлөө өөрийн хувь нэмрийг оруулах болсон байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Сум бүр дотуур байртай, ХХТ-тай учраас иргэд олон нийт, байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах боломжтой. Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд материаллаг зүйлээс гадна байгууллага хамт олон өөрсдийн чадвар, давуу талыг ашиглан тэднийг төлөвшүүлэх, хамтрах, сургах боломжтой. Байгууллагууд ээлжилсээр хагас жилд 1 удаа хуваарь нь таардаг тул тухайн байгууллагын ажилтнуудад хүндрэл болдоггүй.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Сумын засаг дарга тухайн сумынхаа Хүүхдийн зөвлөлийн дарга байдаг учраас байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулбал зүгээр. Иргэдийн сайн дурын оролцоог нэмэгдүүлж ажиллах нь тасралтгүй байдлыг хангаж, хэвшил болгодог сайн талтай.

СУРГАМЖ: Байгууллага нь нийт хамт олноороо ирэх тохиолдол гардаг тул багийн зохион байгуулалтыг хийх, ХХТ-д улавч өмсдөг дэгийг ойлгуулах, материаллаг зүйлийн дэмжлэгээс илүү хүүхдүүдэд ажил мэргэжилтэйгээ холбоотой шинэ сонин мэдээллийг түлхүү өгөх зэрэгт анхаарч ажиллах нь чухал.





Сайн туршлага: **МИНИЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ**

Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМ**

АГУУЛГА: 1-5 дугаар ангийн дотуур байр, айлд амьдардаг хүүхдүүдэд ХБЦНХ-ийн Гүйгч уншигч, Бяцхан театр, Үлгэрээс сурах юм их бий, Уншсанаа бусдад илэрхийлэх, Үлгэрийн цаг зэрэг олон аргаар сургалтыг зохион байгуулснаар хүүхдийн унших, ярих, найруулан бичих чадвар ахисаар байгаа тул тус

хөтөлбөрийн аргуудыг 3а ангийн багш Д.Мөнгөнчимэг удирдаж буй ангийнхаа өдөр тутмын хичээлд нэвтрүүлсэн юм.

Боловсрол олгоно гэдэг ганцхан сургууль, багшийн ажил биш эцэг эхчүүдийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа чухал учраас ангийн сурагчдын уншсан зүйлээ өөрийн үгээр ярих, зохиолоос ургуулан бодох, бусадтай санаа бодлоо нээлттэй хуваалцах чадварыг хөгжүүлэх зорилгоор гэр бүлийн гишүүдийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх “Миний хөгжлийн хөтөч” дэвтрийг санаачилсан.

Миний хөгжлийн хөтөч дэвтрийн хүрээнд хүүхэд бүр гэртээ багшийн бэлтгэж өгсөн тараах материал бүхий сургамжит өгүүллэг, үлгэрээс сонгон авч, гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран унших, ойлгосон зүйлээрээ эх зохиох, утга санааг ярилцах, үргэлжлүүлэн зохиох, чээжээр бичих зэргээр 1 материал дээр олон талаас нь ажилладаг. Энэ бүхнийг эцэг эх, гэр бүлийн гишүүдтэйгээ хийх ба Миний хөгжлийн хөтөч дэвтэрт гэр бүлийн гишүүд тэмдэглэл хөтлөн баталгаажуулж явуулдаг.

Гэр бүлийн гишүүд хамтдаа уншиж, ярилцах учраас Сургамжит өгүүллэг 1, 2 номын эхүүд, Монгол ардын үлгэрүүдээс сонгон тараах материал бэлтгэхэд тохиромжтой байдаг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Хүүхдүүдийн хувьд амжилтаа ахиулан, номтой нөхөрлөх нэгэн хөшүүрэг болж байна. Унших хурд, эхийг ойлгон унших, эхээс сонгож унших, уншсан эхээ дарааллын дагуу ярих чадварууд нэмэгдсэн. Эхээс чээжээр бичих, алдсан алдаагаа олох, засах чадварууд сайжирсан. Мөн найз нөхдөдөө уншсан зохиолоо ярьж, санаа бодлоо солилцон, зохиолын эерэг санаа, сөрөг дүр зэргийг хамтран олж хардаг болсон.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ХБЦНХ-ийн аргууд ойлгомжтой тул сургалтад шууд ашиглах боломжтой. Миний хөгжлийн хөтөч дэвтэр болон тараах материал бэлтгэхээс өөр ямар нэгэн материаллаг зүйл шаардагдахгүй.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Уг дэвтрийг сурагчдын улирлын амралтаар өгч явуулж байх. Тараах материалын сэдвийг сургамжит өгүүллэг, байгаль эх орноо хайрлах, монголын уламжлалт зан заншил гэх мэт сэдвээр баяжуулан, сонирхолтой хэлбэрээр бэлтгэн өгөх. Хүн орчин, Математикийн хичээлийн агуулгыг багтаасан тараах материал бэлтгэх.


СУРГАМЖ: Эцэг эх эхэн үед хүүхэдтэйгээ ажиллахдаа өдөр бүр биш, 2-3 өдөр өнжиж ажилладаг байсан. Эцэг эхийн хуралд гүйцэтгэлийн тайлан танилцуулснаас хойш бүх эцэг эх өдөр бүр хүүхдийнхээ хөгжилд анхаарч хамтран ажилладаг болсон. Тараах материалын эх бага хэмжээтэй байх ба гэр бүлийн гишүүдэд нэгийг бодуулсан агуулгатай байх. Өрх бүрт ном дутмаг, зарим өрхөд ном огт байдаггүй тул тараах материалыг хүрэлцээтэй бэлтгэх хэрэгтэй.

“ Чээжээр бичиж чадна. ”

№	Бичсэн эхийн нэр	Сар өдөр	Үгийн тоо	Гэр бүлийн гишүүн хэн болох	Гарын үсэг
1	Бор шувуу	2/25	31-30	Том	<i>[Signature]</i>
2	Ногоодал	2/25	48-39	Том	<i>[Signature]</i>
3	Могоо туга	2/26	32-30	Том	<i>[Signature]</i>
4	Ус зуурагч хөдөр	2/26	41-37	Том	<i>[Signature]</i>
5	Муга шувуу	2/27	41-39	Том	<i>[Signature]</i>
6	Туга шувуу	2/27	40-38	Том	<i>[Signature]</i>
7	Дүгнэлт АУБагш			Том	<i>[Signature]</i>

Баярлалаа Могоо

Та бүхэн хүүхдийнхээ бичих чадварыг сайжруулахад санаа тавина гэдэгт итгэлтэй байна.
Хамтран ажилласанд баярлалаа. АУБагш



Сайн туршлага: **ХӨГЖИЛ, ТӨЛӨШЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМ**

АГУУЛГА: ХБЦНХ-т хамрагдаж буй сурагчдын ахиц, амжилтыг улирал, жилээр тооцон ажиллаж, таван жилийн хугацаанд энэхүү хөтөлбөрт хамрагдсан сурагчдад “Хөгжил, төлөшлийн гэрчилгээ” олгодог болсон. Сурагчдын төлөшлийг үнэлэхдээ “Үлгэр жишээч”, “Сайн”, “Хангалттай”, “Хангалтгүй” гэсэн үнэлгээгээр үнэлж, чадварыг нь Боловсрол, шинжлэх

ухааны сайдын А/309 дугаар тушаалын дагуу хувиар тооцож үгэн үнэлгээ болох “Онц”, “Сайн”, “Хангалттай”, “Дунджаас доогуур”, “Дэмжлэг хэрэгтэй”, “Хангалтгүй” гэж үнэлнэ.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Есөнзүйл суманд ХБЦНХ хэрэгжиж эхэлснээс хойш 355 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд энэхүү аргаар сурагчдын бүтээлчээр унших, бичих, бодох чадвар ямар түвшинд эзэмшсэнийг нээн илрүүлэх боломжтой. Анги удирдсан багш болон сурагчдын эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ хөгжил төлөвшил, чадвартай улирал бүр танилцаж, багштай хамтран ажилладаг.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Өөрсдийнхөө нөөц боломжийг ашиглах учраас тусгай хөрөнгө шаардахгүй. ХБЦНХ-ийн сургагч багш нар болон анги удирдсан багш нар цаашид өөрийн ангийн суралцагчдын хөгжил төлөвшил, эзэмшсэн чадварыг улирал бүрээр тооцон ажиллах боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Хөтөлбөрт хамрагдаж буй сурагчдынхаа гараа, барианы үнэлгээг тогтоон, ахиц амжилтын тэмдэглэлийг улирал, жилээр хөтөлж ирсэн учраас суралцагчдаа үнэлж дүгнэхэд хүндрэл бэрхшээл бага. Цаашдаа төсөл дууссан ч гэсэн “Хөгжил, төлөшлийн гэрчилгээ”-г бага, дунд, ахлах ангийн хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлог, тухайн ангийн судлагдахуунтай уялдуулан багш бүр өөрийнхөө хөрсөн дээр буулган хэрэгжүүлнэ.

СУРГАМЖ: “Хөгжил, төлөшлийн гэрчилгээ”-г дунд, ахлах ангийн багш нар баяжуулан хоорондоо солилцон хэрэглэж хэвшиж байгаа бөгөөд багш нар сурагчдын хөгжил, төлөшлийн бүхэл бүтэн сантай болж, багш нар санал бодлоо солилцон илүү сайжруулж, илүү олон багш нарт түгээх боломжтой болсон. Фото цаас эсвэл өнгийн цаасыг зөв сонгож хэрэглэх хэрэгтэй.

Сайн туршлага: **БЯЦХАН ОНБЗ**
Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
САНТ СУМ**

АГУУЛГА: ОНБЗ-ийн гишүүн Ж.Лхагвадорж дотуур байранд амьдардаг, идэвх санаачилгатай, сурлага, урлаг, спортоор тэргүүлдэг, дунд ангийн 6 сурагчийн бүрэлдэхүүнтэй “Бяцхан ОНБЗ”-ийг 2013 оны 12 сард байгуулсан. Бяцхан ОНБЗ байгуулснаар хүүхэд хүүхдээсээ сурахад илүү нээлттэй, айж ичих, санаа зовох зүйлгүйгээр харилцан тусалдаг, нэг нэгнээсээ үлгэр дуурайлал авдаг

болсон. Мөн нэг байранд ойр байдаг учир дотуур байрандаа дүү нартаа хичээлийг нь зааж, тоглож наадсанаар хамтдаа хөгжих боломж бүрдсэн.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Бяцхан ОНБЗ-ийн гишүүд зорилтот бүлгийн дүү нартаа туслахаас гадна зорилтот бүлгийн хүүхдүүдийн эцэг эхтэй хамтран ажиллаж, ном, тоглоомын багц ашиглах зааварчилгааг бодитоор зааж зөвлөж (жүжигчилсэн тоглолтоор), бүрэн утгаар нь ойлгуулж чадсан тэргүүн туршлагатай гишүүд юм. Мөн сумын хэмжээнд төрийн бүх байгууллагад өөрсдийн үйл ажиллагааг сурталчлан таниулах “Хүүхдийн төлөө та бүхэн юу хийж чадах вэ?”, “Хүүхдийг зодож шийтгэхгүй байя” зэрэг олон уриалга гаргаж, томчуудаас санал сэтгэгдлийг нь цуглуулж, бүтээлчээр хамтарч ажиллаж байгаа нь томчуудад хүрэх нөлөөллийг ихэсгэж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ОНБЗ-ийн гишүүд өөрсдийн ажилтай учир “Бяцхан ОНБЗ”-ийн гишүүд ОНБЗ-ийнхөө ах эгч нарт тусалж ажлыг хөнгөвчилдөг, хүүхдүүдийн хүсэл сонирхолд нийцэх шинэ санал, санаачилга гаргаж ажилладаг тул ОНБЗ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тус нэмэр болсоор байна. Манай Бяцхан ОНБЗ-ийн үйл ажиллагааг дэмжиж ЗДТГ-аас “Бяцхан ОНБЗ”-ийн гишүүдийг ногоон цамц, малгайгаар ижилсүүлсэн нь хаана ч явсан таних тэмдэг болдог.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: “Бяцхан ОНБЗ”-ийн гишүүд маань үйл ажиллагаагаа сургуулийн бүх сурагчдад үйл хөдлөл бүрээрээ таниулж сурталчилж байгаагаас Бяцхан ОНБЗ-ийн гишүүн болох хүсэл сонирхолтой хүүхдүүдийн тоо нэмэгдсээр байна. Бяцхан ОНБЗ-ийн гишүүдийн хамгийн том ажил бол зорилтот бүлгийн хүүхдүүдээ бүжиг, дуу, шүлэг, сурлага гэсэн ангиллаар хуваан авч, ангилал тус бүрээр хөгжүүлэх ажил хийж байгаа явдал юм.

СУРГАМЖ: Анх 6 хүүхдийн бүрэлдэхүүнтэй байсан жижиг ОНБЗ маань 9 гишүүнтэй болж улам өргөжиж байна. Хүүхэд хүүхдээсээ сурахад илүү нээлттэй, ойр байдаг учир дотуур байрандаа дүү нартаа хичээлийг нь зааж, тоглож наадсанаар хамтдаа хөгжих боломж бүрдсэн. Бяцхан ОНБЗ-ийн сурагчид маань бүгд малчдын хүүхэд учраас гэрээсээ хол сургуульд сурахад бага ангийн хүүхдэд ямар, ямар бэрхшээл тулгардгийг сайн мэддэг бөгөөд дүү нарынхаа хэрэгцээг мэдэрч, чин сэтгэлээсээ тусалж байгаа нь харагддаг.





Сайн туршлага: **БИДНИЙ ТОГЛООМ**
Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ТАРАГТ СУМ**

АГУУЛГА: Монгол өв уламжлалаасаа суралцахад чиглэсэн бүтээлч, оюуны тоглоом наадгайгаар тоглуулж, сэтгэхүйг хөгжүүлэх зорилгоор дотуур байрын ХХТ-д оньсон болон хөлөгт тоглоомын булан байгуулан ажиллуулж байна. 5-р ангийн багш бүр 2 хөлөгт тоглоом урлан анх эхэлж байсан бол энэ намар ЕБС-ийн анги бүрийн дунд монголын уламжлалт 3 хөлөгт тоглоом урлах уралдаан зарлан явуулж, тоглоомын санг баяжууллаа.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Хөлөгт тоглоомоор тоглосон хүүхдийн анхаарал төвлөрөлт сайжирч, аливаа зүйлийг олон өнцгөөс харж дүгнэх чадвар нь нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Эцэг эх, гэр бүлээсээ тусдаа айлд болон дотуур байранд амьдарч буй бага ангийн хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийгэмших, сэтгэн бодох, танин мэдэхүйн чадварыг нь илүү хөгжүүлэх, мөн тоглонгоо суралцах боломжоор хангахад энэхүү булан нь ихээхэн дэмжлэг болж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Оюуны хөлөгт тоглоомын суурь нь хийхэд хялбар, олон үйлдлээр тоглох боломжтой, эцэг эхчүүд болон багш нар гарын доорх материал ашиглан хийх боломжтой, монгол айл бүхэнд шагай байдаг зэрэг нь энэ тоглоомыг цаашид хөгжүүлэн баяжуулахад ойр дөт байна.

Хөлөгт тоглоом нь хүмүүжлийн хувьд хүүхдэд зориг, тэвчээр хатуужил суулгахаас гадна тоглоомын дүрмийг баримтлан шударга наадах, ахмад хүмүүс, найз нөхөдтэйгөө зөв харилцах, өөрийн болон нөхдийнхөө амжилтад баярлах, өөртөө итгэлтэй болох зэрэг нийгэмшихүйн эерэг дадал зуршлыг төлөвшүүлдэг.


ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Цаашид жил бүрийн 10 сарын 1-нд сургууль дээрээ “Монголын уламжлалт тоглоомын өдөр”-ийг зохион байгуулж байхаар тогтсон бөгөөд энэ үйл ажиллагаагаар тоглоомын санг нэмэгдүүлж байхаар боллоо.

СУРГАМЖ: Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогийг ихэд анхаарч үзэх хэрэгтэй. Монголын уламжлалт хөлөгт тоглоомууд нь дан ганц шагайн наадгай биш маш олон төрлийн тоглоом байдгийг бид судалж мэдсэн. Үүнээс бага насны хүүхдийн сэтгэхүйд таарахуйц тоглоомыг сонгох нь чухал байлаа.

Сайн туршлага: **14 ХОНОГИЙН АХИЦ,
АМЖИЛТЫГ ДҮГНЭХ НЬ**
Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
УЯНГА СУМ**

АГУУЛГА: ХБЦНХ-ийн хүрээнд бага ангийн анги даасан багш нар хичээл бүрийн стандартын жишиг даалгаврыг гаргадаг бөгөөд бага боловсролын сургалтын менежер 14 хоног тутам анги бүрээс гарааны үнэлгээг тогтоож, дараагийн 14 хоногт түүний бариа болон хүүхэд бүрийн ахиц, амжилтыг тусгайлан хүүхэд нэг бүр дээр тодорхойлж, аль ангийн, ямар сурагч, ямар түвшинд явааг судалж, ангийн багшид аргазүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Мөн үүний дагуу хүүхэд нэг бүр дээр хяналтын график байгуулан дүн шинжилгээ хийж, ахиц нь хэр хэмжээнд байгааг тогтмол хэмждэг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Багш нарын бичиг цаасны ажлыг багцалж, хүүхэд нэг бүртэй багш, менежер, эцэг эх хамтарч ажиллах, тэдний ахиц, амжилтыг үнэлэх, урамшуулах, ямар хичээл дээр хоцорч яваа зэргийг судлах, багаар үр дүнтэй хамтарч ажиллах боломжтой. Үүний үр дүнд бага ангийн стандартын хоцрогдолтой сурагч байхгүй болсон бөгөөд ангийн стандартын олимпиадад амжилт гаргаж байна. Тухайлбал, “Эх хэл - Эрдмийн түлхүүр” ангийн стандартын олимпиадад Г.Даваадолгор багштай 2^в анги 2015, 2016 оны Ханхөгшин бүсийн аварга анги, Ж.Эрдэнэбаяр багштай 4^б анги 2015 оны бүсийн аварга, 2015 оны аймгийн аварга, 2016 оны бүсийн аварга, МУГБ Н.Баяртогтохын нэрэмжит бүсийн олимпиадад 1-р байр, Т.Мөнхзул багштай 3^б анги МУГБ Н.Баяртогтохын нэрэмжит бүсийн олимпиадад 2-р байр, Ханхөгшин бүсийн олимпиадад 2015 онд 2-р байр, 2016 онд 2-р байр, А.Ундрах багштай 5^а анги МУГБ Н.Баяртогтохын нэрэмжит бүсийн олимпиадад 2-р байр, 2015 оны бүсийн 2-р байр, 2016 оны бүсийн 2-р байр, Н.Долгосүрэн багштай 1^а анги 2016 оны сургуулийн аварга, 2016 оны бүсийн 4-р байранд оров.



“Тоо бодож оюунаа хөгжүүлье” ангийн стандартын олимпиадад Ц.Төмөрхуяг багштай 1^б анги 2016 оны Ханхөгшин бүсийн аварга, 3-р шатны аймгийн аварга анги, Б.Оюун багштай 2^б анги 2015 оны бүсийн 2-р байр, 2016 оны бүсийн 1-р байр, аймгийн 2-р байр, Т.Азжаргал багштай 3^а анги 2015 онд 2-р байр, 2016 онд 3-р байр, Д.Дэлгэрмаа багштай 4^а анги 2015 онд 2-р байр, 2016 онд 2-р байр, Ш.Бямбасүрэн багштай 5^а анги 2016 онд 3-р байр, бүсийн эрүүл мэндийн хичээлийн стандартын олимпиадад 2-р байранд орсон сайхан амжилт гаргалаа.

14 хоногийн ахиц, үнэлгээг хүүхэд нэг бүр дээр хийхэд сүүлийн 2015-2016 оны стандарт хангалт эрс өссөн байгаа нь бидний энэ сайн туршлагын үр дүн юм.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Бага ангийн багш бүрийн ажлын үнэлгээнд 14 хоногийн ахиц амжилтын үнэлгээг бүрэн тусгасан бөгөөд бага ангийн сургалтын менежер 14 хоногийн үнэлгээнд тогтмол хяналт тавин ажиллаж, сурагч нэг бүр дээр ахицын үнэлгээг хийж хэвшсэн. Манай сургуулийн хувьд зөвхөн айлд болон байранд суудаг сурагчдаар хязгаарлахгүй бага ангийн 321 сурагч нэг бүр дээр үнэлгээ хийж хэвшсэн.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: 2014-2016 он буюу сүүлийн 3 жил энэ үнэлгээний үр дүнг нь үзэж байна.

СУРГАМЖ: Энэхүү арга, аргачлалыг хэрэгжүүлэхийн тулд тухайн ангийн стандартын шалгалтыг багш нарын үр дүнгийн үнэлгээнээс хасаж өгөх нь хамгийн зөв арга байсан. Багш нарын үнэлгээнд ангийн стандартыг оруулж тооцох үед сурагчдын үнэлгээ буруу гарах үе байсан. Тийм ч учраас үр дүнгийн үнэлгээнээс стандартыг хасаж тооцдог болсон цагаас сурагчдын үнэлгээ бодитой гардаг болсон юм.

Сайн туршлага: **АЛДААГҮЙ БИЧИЖ
СУРЪЯ**

Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАЙРХАНДУЛААН СУМ**

АГУУЛГА: Монгол хэлний хичээл дээр “Халаас тоолох” аргыг “Үг тоолох” аргазүй болгон хөрвүүлэн заах

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ХБЦНХ-ийг хэрэгжүүлэхдээ бага ангийн багш нартаа чадавхжуулах сургалтыг зохион байгуулж багш нараа бэлтгээд, багш бүр өөрсдийн ангийн зорилтот хүүхдүүдтэй тулж ажилласан нь илүү үр дүнтэй болох нь харагдаж байлаа. Иймд бага ангийн 7 бүлгийн 7 багш зорилтот бүлгийн 53 хүүхэдтэй хөтөлбөрөөр ажиллаж эхэлсэн бөгөөд чээжээр алдаагүй, зөв бичүүлэх аргазүйг туршин нэвтрүүлээд байна.

3-р ангийн Монгол хэлний хичээл дээр эхийг зөв хуулан бичих, эхийг зөв нүдлэх, эхийг чээжээр зөв бичих дадлыг суулгахын тулд “Халаас тоолох” аргазүйг хөрвүүлэн заасан нь үр дүнтэй байсны дээр бусад хичээл дээр ашиглах боломжтой байгаа нь олзуурхуштай байлаа.

Эхийг чээжээр зөв бичих:

Багш дараагийн хичээл дээр бичих эхийг гэрийн даалгаварт сайтар нүдэлж ирэхийг даалгавар болгон өгнө. Сурагчид эхээ нүдлэн, хүнд үгсийг дэвтэртээ бичиж ирнэ. Багш хичээл дээр эхийг 3-5 удаа сайтар нүдэлж уншихыг зөвлөнө. Сурагчид уншсаны дараа эхүүдийг доош харуулан тавиулаад тухайн эхэд орсон хүнд үгсийг тараан өгч нүдлэхийг зөвлөнө. Сурагчид хүнд үгсийг заасан хугацаанд нүдлэн тогтоохыг оролдоно. Хугацаа болмогц хүнд үгийн хайрцганд сурагчид үгээ хийнэ.

Багш эхлээд нүдлүүлсэн хүнд үгсээ чээжээр бичүүлнэ. Сурагчид хүнд үгсийг бичиж дуусаад нөгөө багтайгаа солбин засна. Зассаны дараа алдаагаа дүрмээр нь тайлбарлан ярилцана. Үгсээ хүндээс нь хөнгөн рүү ангилан ялгана. Ангилсны дараа харилцан ярилцаад, дахин чээжээр бичнэ. Энэ мэтчилэн 2-3 удаа хүнд үгсээ ялган бичээд, дараа нь өнөөдрийн эхээ чээжээр бичихэд алдаж бичих нь багассан, эсвэл огт алдаагүй бичсэн байх нь элбэг. Энэ нь



тухайн хүүхдэд урам зориг, итгэл өгөхөөс гадна багшид ч мөн адил урам өгдөг. Ийнхүү уг аргагүйг хичээл бүртэйгээ холбон зааж, эх чээжээр бичих бүртээ ашиглавал багшийн гарт нь орж сурагчид ч тухайн хичээл ямар аргагүйгээр хэрхэн яаж явах дарааллыг мэддэг болдог. Ингэснээр сурагч юу хийхээ урьдаас мэдэж, хичээлдээ ухамсартайгаар дэс дарааллын дагуу идэвхтэй оролцдог болдог.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Хичээллэх танхим, сургагч багш болон БАЗАН-ийн багш нар, эцэг эхийн хамтын ажиллагаа бэхжсэн, сургалтын аргагүй, хэрэглэгдэхүүн, сургалтын материаллаг баазаар хангагдсан зэргээр нөхцөл бололцоо бүрдсэн. Хүүхдийнхээ бичих чадварт анхаарч байгаа хэн боловч хэрэглэхэд боломжтой бөгөөд аль ч ангийн хэдэн ч настай хүүхэд хэрэглэж болохоороо давуу талтай.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Энэхүү хөтөлбөрийг сургуулийн бага ангийн сургалтын менежер ажлын төлөвлөгөөндөө оруулан багш бүртэй хамтран ажиллаж байна. Тогтсон хугацаанд хуваарийн дагуу хичээллэснээр багш нар сурагчидтайгаа жигд ажиллахаас гадна ангийн сурагчдын сурлагын чанарт мэдэгдэхүйц ахиц гарч байгаа. Цаашид энэ маягаар хэрэгжүүлээд явах бүрэн боломжтой бөгөөд нэмэлт материал, хэрэглэгдэхүүнээр шинэчлэн бааз сууриа бэхжүүлж, илүү өргөн хүрээг хамруулан хэрэгжүүлж болно.

СУРГАМЖ: ХБЦНХ-ийг хэрэгжүүлэхэд даасан ангитайгаа ажиллавал илүү үр өгөөжтэй, чанартай байх нь ажиглагдсан. Мөн сурагч хичээлээс хоцрогдох нэгэн шалтгаан нь гэрийн даалгавар хийхэд туслах хүн байхгүйгээс болдог. Иймд дотуур байрын багш, үйлчлэгч нартай хамтран хичээл хийж байх хугацаанд туслах, хамтран хийх арга хэмжээ авсан нь хүүхдэд дэмжлэг болсон.

Сайн туршлага: **ШАГАЙН БОГЦ**
Хэрэгжүүлэгч: **СҮХБААТАР АЙМГИЙН
БАЯНДЭЛГЭР СУМ**

АГУУЛГА: Хүүхэд бүрийг хөгжүүлэх хамгийн энгийн бөгөөд уламжлалаас суралцах эх үндэс болсон шагай наадгайгаар дамжуулан хүүхдийн “тоглолгоо суралцах” үйлийг дэмжихээр Баяндэлгэр сумын ОНБЗ “Нэг хүүхэд-нэг шагай” аян зохион байгуулсан юм. Хүүхдүүдээс цугларсан 300 гаруй шагайг угааж цэвэрлэн, тэр бүр хүмүүсийн мэдэхгүй шагайгаар наадах 24 арга бүхий хэрэглэхэд хялбар гарын авлага бэлтгэн ГБОСБХ-ийн ном, тоглоомын багцад нэмэлтээр хийсэн ба давхар ХХТ-д байрлуулж хүүхэд, эцэг эхчүүдэд тоглолгоо суралцах, хөгжих боломжийг бүрдүүлж өглөө. 2015 оноос уг туршлагыг хэрэгжүүлсэн бөгөөд МНӨ, ХХТ-аар үйлчлүүлж буй хүүхдүүдийн эцэг эхчүүд сайшаан, ширэг, олбог хийж өгсөн.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Хүүхдүүд тоглох явцдаа өөр хоорондоо нээлттэй харилцаж, тоглох аргаа хүсэл сонирхлоороо чөлөөтэй сонгож, хамтран шийдвэр гаргаж байна. Бие бялдрын хувьд гарын булчинг чангаруулж, хурдан шаламгай, хянамгай хөдөлгөөнтэй болгож, нүдний харааг хөгжүүлж байдаг. Зан чанарын хувьд хүлээцтэй, дэг журамтай, ажигч гярхай зэрэг сайн зуршлыг бий болгодог. Мөн сэтгэхүйн хувьд хурдтай сэтгэх, оновчтой шийдвэрийг богино хугацаанд гаргах, орон зайн мэдрэмж хөгжих зэрэг давуу талууд бий болно.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Баяндэлгэр сумын ОНБЗ нь нэгдүгээр ангид элсэн орсон ХБЦНХ-т хамрагдаж байгаа сурагчдыг шагай наадгайн бүлгээр дамжуулан хөгжүүлдэг болсон. Хийгдэж буй үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан “Үндэсний тоглоомын өдөрлөг” бүхий нэрэмжит өдрийг жил бүрийн 11 сарын 11-нд зохион байгуулж, хүүхдийн оролцооны бүлгийн сурагчдаар дамжуулан ангиудад олонд танигдаагүй шагай наадгайн аргыг таниулдаг байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: МНӨ, ХХТ, Бага боловсрол нөхөн олгох сургалтын танхимд байнгын багш байх учир хүүхдүүд чөлөөт цагаараа шинэ аргад суралцан тоглон наадах боломжтой юм.



СУРГАМЖ: Шагай цуглуулахдаа хүүхэд бүрээс авах учир хүндрэл үүсгэлгүй бага тоогоор хүлээн авах, шагай наадгайн гарын авлага дахь тайлбарыг энгийнээр ойлгомжтой өгүүлэх, шагайг арвижуулах аяныг хийдэг байх, байнга шагайг угааж ариутгадаг байх хэрэгтэй.

Шагайн наадгайн аргууд:

- | | |
|-----------------------|---------------------------------------|
| 1. Та нэмэх | 13. 12 жил |
| 2. Андгайцах | 14. Төгс |
| 3. Цэг түүх | 15. 4 хошуу мал өрөх |
| 4. Шагай сэлгэх | 16. Хонхор дахь наадаан |
| 5. Бөнжигдөх | 17. Долоон дуугүй |
| 6. Дөрвөн бэрх | 18. Нэг зүс буулгах |
| 7. Жаран шагай няслах | 19. Хонь хургалуулах, ямаа ишиглүүлэх |
| 8. Бөгцөг няслах | 20. Шагай таалцах |
| 9. Морь уралдуулах | 21. Муур цөмөх |
| 10. Тэмээ уралдуулах | 22. Алаг мэлхий өрөх |
| 11. Алтан хумбарай | 23. Дөрвөн бэрх минийх |
| 12. Жомброй хаях | 24. Шагай харвах |

Сайн туршлага: **ХҮҮХЭД ХӨГЖИЛ**
Хэрэгжүүлэгч: **СҮХБААТАР АЙМГИЙН**
ЭРДЭНЭЦАГААН СУМ



АГУУЛГА: ХБЦНХ-ийн аргагүйг багш бүр судлан, хичээлд бүтээлчээр ашиглаж хэрэгжүүлсэн нь сурагчдын унших, бичих, ярих, сонсох, бодох, сэтгэх, бүтээх үйлийг хөгжүүлсэн төдийгүй багш бүрт ур чадвараа ахиулах боломж олгосон. Тиймээс Эрдэнэцагаан сумын ОНБЗ ХБЦНХ-ийн аргагүйг өргөн хүрээнд ашиглах, идэвхтэй аргын үр нөлөөг сурагчдад ойртуулах зорилгоор “Хүүхэд хөгжил” цаг, багш нарт үр дүнг таниулах, ухуулах зорилгоор “ХБЦНХ-өөр хэлэлцүүлэгт хичээл”-ийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. “Хүүхэд хөгжил” цагаар бага анги хичээлийн хуваарьт долоо хоногт нэг удаа ХБЦНХ-ийг тусгайлан оруулж, бага ангийн сургалтын менежер батлан, жилд дунджаар анги бүрт 37 цагийн хичээлийг оруулж хэвшээд байна. Мөн бүрэн дунд сургуулийн бүх багш нарыг хамруулан ХБЦНХ-ийн хичээл, үйл ажиллагаанд ашиглах хэлэлцүүлэгт хичээлийг 2015-2016 оны хичээлийн жилд зохион байгуулж, нийт 60 багш оролцож, багш бүр аргагүйгээ давхардуулалгүй судалж, ур чадвараараа өрсөлдсөн юм.

ҮР ДҮН, НӨЛӨӨЛӨЛ:

ХБЦНХ-ийн аргуудыг өдөр тутмын хичээлд ашигласны үр дүнд багш нарын хувьд:

- Бага ангийн багш нарын ур чадвар, аргагүйд ахиц гарч, ажлын байран дээрээ хөгжиж, чадваржсан.
- Дунд ангийн багш нарын хичээл заах аргад эергээр нөлөөлөн мэргэжлийн бүх багш нар хэлэлцүүлэгт хичээлээр дамжуулан хичээл үйл ажиллагаандаа ашиглан дор хаяж 2 аргыг судлан өөрийн болгосон.
- Хичээлийн үйл явцыг идэвхжүүлэх, дараагийн сэдэвт шилжих зэргээр аргуудыг ашиглан маш хурдан хөрвөж чаддаг.

- Хонь ба дэвтэр аргыг хөрвүүлэн ашиглан улсын ур чадварын уралдаанд амжилттай оролцсон.
- Хичээлийг сонирхолтой, хүүхдийн идэвх оролцоог өрнүүлсэн хэлбэрээр явуулдаг болсон ба шинийг эрэлхийлдэг, аргазүйгээ баяжуулан хэрэглээ болгох хандлагатай болж байна.
- Өөрийн ур чадвар, аргазүйгээ үнэлүүлдэг, бусдадаа танилцуулдаг болсон.


ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ХБЦНХ-ийн аргуудыг хувирган хичээлдээ ашиглах боломжтой. ХБЦНХ-ийн аргуудыг хүүхдүүдэд төдийгүй олон нийтийг идэвхжүүлэх сургалтад ашиглаж байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулна. Хэлэлцүүлэгт хичээл зохион байгуулах үйл ажиллагааг ОНБЗ уламжлал болгон хэвшүүлэхээр энэ жил цэцэрлэгийн багш нарт ХБЦНХ-ийн сургалтуудыг явуулж байна. БАЗАН нь багш нарын дундах хэлэлцүүлгийг тогтмол өрнүүлж, зөвхөн уралдаан төдийгөөр хязгаарлахгүйгээр үр дүн, үр нөлөөгөө таниулах туршлага солилцох цэг болгон багш бүрийг идэвхжүүлнэ.

СУРГАМЖ: Баримтжуулалт хэрэгтэй. Багш бүр зөвхөн өөрийн судалсан цөөн аргаар хязгаарлагдахгүй цааш суралцах боломжийг хамт олондоо бий болгох журмаар суралцах хэрэгтэй.

3 БАГА БОЛОВСРОЛ НӨХӨН ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТУРШЛАГА





Сайн туршлага: **ГЭРЭЭР БОЛОВСРОЛ НӨХӨН ЭЗЭМШИХ НЬ** Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМ**

АГУУЛГА: Сургуульд огт сураагүй, сурах дургүй хүүхэд, түүний эцэг эхтэй уйгагүй ажиллаж амжилт гаргасан. Төслийн хүрээнд судалгаа гарган, тус хүүхэдтэй ажиллах төлөвлөгөө гарган, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Эцэг эх ба хүүхдийн

түвшинг тогтоож, модулийг танилцуулан юу, юуг яаж ашиглах талаар зөвлөгөө өгсөн. Эцэг эхэд нь хөтөлбөрийг танилцуулан, сэдвүүдийг нэг бүрчлэн тайлбарлан таниулж, зөвлөн тусалсан. Хүүхэдтэй танилцан хичээлийн тухай ярьж тайлбарлан, гэртээ боловсрол эзэмших, сурах үйлд суралцах, сурагч болбол ямар сайхан байх тухай ярьж, сэтгэгдлийг сонсон яриа өрнүүлж, сурах сэдлийг төрүүлэх, итгэлийг нь олж авах, гэрээр амжилттай суралцсан хүүхдүүдийн бодит жишээ, баримтат кино гэх мэт нүдэнд харагдахуйц зүйлээр хандлагыг өөрчлөх арга замыг сонгож ажиллах нь хамгийн чухал. Энэ нь хүүхдийг амжилттай сургах гүүр нь юм. Хүүхдэд гарч буй өөрчлөлт бүрийг эцэг эх, асран хамгаалагч нарт ойлгуулах нь тэдний оролцоог нэмэгдүүлэх боломж болж байв.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Эцэг эх, хүүхдийн хандлагад нөлөөлж чадсан. Тухайн хүүхэд маань ЕБС-д элсэн орж, их амжилт гаргасан. Чиглүүлэгч багш нарын зүгээс эцэг эх, хүүхэдтэй ажиллах шинэ аргазүй, аргачлалд суралцаж туршлагатай боллоо.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Эцэг эх, гэр бүлийн хандлагад эерэг өөрчлөлт гаргахын тулд чиглүүлэгч багш нар уйгагүй ажиллаж, харилцаж байв.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Насан туршийн боловсролын багшийн ажлын байрын тодорхойлолт, ажлын үр дүнгийн гэрээнд заалт оруулан үүрэгт ажил болгон хэвшүүлэх боломжтой.

СУРГАМЖ: Хүүхдүүдийн гэрээр очиж эргэлт хийх, зөвлөгөө өгөх унааны зардлын асуудалд анхаарч, Насан туршийн боловсролын төв (НТБТ)-ийн амьдрах ухааны сургалтын зардалд тусгаж өгөх хэрэгтэй. Цаг агаарын байдал, замын саад бэрхшээл, оршин суугаа газрын алслагдмал байдал нь цаг хугацааны хувьд саатуулдаг тул тэдгээрийг тооцон сургалтын агуулгаа тодорхойлох хэрэгтэй.

Сайн туршлага: **СУРАХАД ХЭЗЭЭ Ч
ОРОЙТДОГГҮЙ**

Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН
МАТАД СУМ**

АГУУЛГА: Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр (ББНОХ)-ийг амьдрах ухааны сургалттай хослуулан эцэг эхчүүдэд бичиг үсгийн боловсрол олгох аргагүй

Бичиг үсгийн чадвар сул эцэг эхчүүд хүүхдэдээ гэр бүлийн орчинд хангалттай хэмжээнд сургуульд

бэлтгэж чаддаггүйн улмаас хичээлийг алгасаж үзэх, багцыг солихгүй удаах, эсвэл бүх номыг уншиж өгсөн гэж худал хэлэх зэрэг бэрхшээл тулгардаг байлаа. Цаашлаад хүүхэд нь 1-р ангид элсэн суралцахад хүүхдийнхээ сурах үйлд дэмжлэг үзүүлж чадахгүйн улмаас сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох оролцоо хангалтгүй байсан. Тиймээс сумын ОНБЗ-ийн гишүүд эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг амьдрах ухааны оёдол эсгүүр, хоолны технологитой хослуулан заах замаар унших, бичих чадварыг нэмэгдүүлж байна. Амьдрах ухааны сургалтыг насан туршийн боловсролын багш (технологийн багш), бичиг үсгийн сургалтыг ББНОХ-ийн чиглүүлэгч багш удирдан явуулдаг. Суралцагч ээжүүд гэр бүлийн орчинд ББНОХ-ийн модулийг ашиглан суралцаж, 7 хоногт 2-3 удаа сургууль дээр ирж унших, бичих дадлага ажлыг хийдэг. Чиглүүлэгч багш ээжүүдэд гарч буй ахицаас шалтгаалан үгийн сүлжээ бөглүүлэх, үсгийн дарааллыг олуулах, үг бүтээлгэх, хуулан бичүүлэх, үелүүлэн уншуулахаас гадна ХБЦНХ-ийн Үгийн эрэлд аргыг ашиглан сургалт зохион байгуулж байна.

Унших, бичих дасгалын дараа технологийн дадлага хийх ба оёдол эсгүүр заалгах явцад технологийн багш өнөөдөр ямар үсэг үзсэн, ямар үг уншиж, өгүүлбэр бичсэн тухай ярилцан, уншсан сэдэв, үзсэн үсэгтэй холбоотойгоор даавууны өнгө сонгуулж, оёдол хийх явцад нь үсгийг сэргээн сануулдаг. Жишээ нь: "Х" үсэг үзсэн бол ХАР өнгийн даавуу, утсыг сонгуулах, ХАР өнгө гэхэд ямар, ямар үсэг орж байгаа тухай асуух, бичвэл хэрхэн үелж бичих гэх мэтээр өмнө нь үзсэнийг бататгадаг. Түүнчлэн нарийн боов хийх, баярын ширээ чимэглэх сургалтын дараа тухайн бүтээгдэхүүнд орсон орцыг хуулан бичүүлэх, нүдлүүлэх, урт, богино эгшиг нөхүүлэх, орцыг нэмж, хасаж бодуулах зэргээр уншиж, бичих, бодох чадварыг нэмэгдүүлж байна.



**"ХӨНГӨН ЗҮҮШ БЭИГГЭХ" АМЬДРАХ УХААНЫ
СУРГАЛТЫН ДАСГАЛ ДААЛГАВАР**

2018.12.07

А. Үгийг дуурайлган цэвэр бичих

1. Хиам *Хиам Хиам Хиам*
2. Өргөст
хэмх *Хэмх Хэмх Хэмх*
3. Мод *Мод Мод Мод Мод*
4. Хун *Хун Хун Хун Хун*
5. Шувуу *Шувуу Шувуу Шувуу*
6. Хулгана *Хулгана Хулгана Хулгана*
7. Хутга *Хутга Хутга Хутга*
8. Өндөг *Өндөг Өндөг Өндөг Өндөг*

Б. Тохирох үсгийг нөхөж бичих

1. Би ~~алимар~~ хун хийж сурлаа
2. Бид ~~Өндөгөр~~ хулгана хийлээ

Э Зочин

Ээжүүдийн энэхүү идэвхтэй оролцоог ОНБЗ-ийн гишүүд хөхиүлэн дэмжиж, зохион байгуулж буй үйл ажиллагаанд туслагчаар оролцуулах замаар оролцоог нэмэгдүүлэн ажиллаж байна.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Амьдрах ухааны сургалттай хослуулан сонирхолд нь түшиглэсэн тул эцэг эхчүүдийн унших, бичих чадвар нэмэгдэж байна. Тэд хүүхдэдээ цаг зав гарган, богино өгүүллэг, үлгэр уншиж өгч хүүхдийнхээ боловсролд анхаардаг болсон. Түүнчлэн сурсан зүйлээ бусад найз нөхөд, ойр зэргэлдээ хүмүүстээ заадаг болсон.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ББНОХ нь Насан туршийн боловсролын үндэсний төв (НТБҮТ) болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ)-ны вэбсайтад тавигдсан тул ямар ч багш, эцэг эх татан авч, гэр бүлийн орчинд бие даан суралцах боломжтой. Сургууль бүрт насан туршийн боловсролын багш байдаг. Тэд насанд хүрэгчидтэй ажиллах бүрэн боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Сумдуудад бага ангийн болон насан туршийн багш нар бүрэн бэлтгэгдсэн. ОНБЗ тухайн суралцагчдаа сайн дурын идэвхтнээр ажиллуулах замаар хөгжүүлэх бүрэн боломжтой.

СУРГАМЖ: Эцэг эхчүүд уншиж, бичиж чадахгүйгээс ичих тохиолдол гардаг тул амьдрах ухааны сургалтыг хослуулах шаардлагатай. Хүн багатай оройн цагаар сургалт явуулдаг тул багш илүү цагаар ажиллах шаардлага гардаг. Модулиас гадна бага ангийн сурах бичиг ашиглах хэрэгцээ байдаг. Хаврын мал төллөлт, ямаа самнах, зун намрын хадлан, өвлийн идэшний цагаар хичээл их тасарч, өмнө үзсэнээ дахин сэргээх шаардлагатай болдог. Эцэг эхчүүд бичиг үсэг сурах чин хүсэл тэмүүлэлтэй байх нь чухал.

Сайн туршлага: **БОЛОВСРОЛ-ХҮҮХЭД
НАС**

Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
УЯНГА СУМ**

АГУУЛГА: Уянга сумын ОНБЗ-ийн дарга, НТБТ-ийн аргазүйч О.Оюунцэцэг болон багш нарын санаачилгаар суралцах боломжгүй, сурах дургүй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгааны улмаас сургууль завсардсан 18 хүүхдийг ББНОХ-т хамруулан, тэдний эцэг эхтэй хамтран ажиллаж, боловсролын үйлчилгээнд хамруулан ЕБС болон НТБТ-д шилжүүлэн сургалаа.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Энэхүү үйл ажиллагааны үр дүнд 7-14 насны 18 хүүхдэд бага боловсрол нөхөн олгов. Үүнээс: ЕБС-ийн нэгдүгээр ангид 2 хүүхэд, гуравдугаар ангид 1 хүүхэд, дөрөвдүгээр ангид 1 хүүхэд, НТБТ-д 7 хүүхэд тус тус шилжин суралцаж, 7 хүүхэд ХИС-гийн төслийн хүрээнд бэлтгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн багц ашиглаж байна. ЕБС-ийн менежертэй хамтран ажиллаж, стандартын шалгалт авч, зохих ангид нь оруулсан бөгөөд дараа нь ч хүүхдээ сургуулийн орчинд дасан зохицоход нь ОНБЗ-ийн гишүүд тусалж байна.

Үр шим хүртэгч хүүхдүүдэд гарааны үнэлгээ хийж, хүүхэд нэг бүртэй ажиллах арга технологийг тодорхойлон, ББНОХ-ийг хэрэгжүүлснээр Монгол хэлний хичээлийн дундаж ахиц нь 7-84%, Математикийн хичээлийн үнэлгээ 9-85% хүрсэн үр дүнтэй байв.

Хөтөлбөрт хамрагдсанаар хүүхдүүдийн суралцах хүсэл эрмэлзэл нэмэгдэж, улмаар ирээдүйн мэргэжлээ мөрөөдөн, түүндээ хүрэх тэмүүлэлтэй болсон юм. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нар нь хүүхдээ сургууль завсардуулсандаа сэтгэл эмзэглэж явдгаа нуулгүй ярьж, цаашид сургах аргазүйтэй болсон, өөрсдөө хөгжсөндөө талархлаа илэрхийлдэг.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Сургалтын аргазүйн хувьд эцэг эхчүүд хүүхдэдээ хичээл зааж өгч, зарим үед хүүхдээсээ суралцаж байгаагаараа цоо шинэ хандлагатай болсон, багш нар нь чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэж, хэрэглэгдэхүүнийг бэлтгэн өгч үнэлж дүгнэдгээрээ онцлогтой байна. Сургагч чиглүүлэгч багш нар нь сумын НТБТ-д ажилладаг учир тэдний ажлын байрын тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд заалт оруулан үүрэгт ажил болгон хэвшүүлснээр багшийн



урамшууллын зардал асуудалгүй болсон. Чиглүүлэгч багш нарын зүгээс эцэг эх, хүүхэдтэй ажиллах шинэ аргазүй, аргачлалд суралцаж туршлагатай боллоо.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Цаашид энэхүү зорилтот бүлгийн хүүхдүүдийг сургах, хөгжүүлэх ажлыг сумдын НТБТ-ийг түшиглэн зохион байгуулах бүрэн боломжтой. Учир нь дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдагчдын зардлыг төсвөөс олгодог бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг нэмж тусгах нь чухал юм. ЕБС, ОНБЗ, НТБТ-ийн хамтын ажиллагаа маш сайн, эцэг эхчүүдийн хандлагад эрс өөрчлөлт орсон зэрэг нь үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрэн хангах суурь болж байна.

СУРГАМЖ: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэрээр очиж эргэлт хийх, зөвлөгөө өгөх унааны зардлын асуудалд их анхаарч, НТБТ-ийн амьдрах ухааны сургалтын зардалд тусгаж өгөх хэрэгтэй. Цаг агаарын байдал, замын саад бэрхшээл, оршин суугаа газрын алслагдмал байдал нь цаг хугацааны хувьд саатуулдаг тул тэдгээрийг тооцон сургалтаа төлөвлөх хэрэгтэй.



Сайн туршлага: **АМЬДРАХ УХААНЫ
СУРГАЛТЫГ ХӨТӨЛБӨРТЭЙ
ХОСЛУУЛАХ НЬ**

Хэрэгжүүлэгч: **СҮХБААТАР АЙМГИЙН
ОНГОН СУМ**



АГУУЛГА: ХБЦНХ-ийн аргагүй, ББНОХ-ийн модулиар хичээллэж буй хүүхдүүдийн сонирхолд тулгуурлан тухайн хөтөлбөрүүдийг талх, нарийн боов, оёдол эсгүүр, мал аж ахуйн тоног төхөөрөмж хийх амьдрах ухааны сургалттай хослуулах замаар сурах идэвх сонирхлыг өрнүүлэх боломжийг Онгон сумын ОНБЗ-ийн хамт олон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хүүхдүүдийн нийгэмшил, төлөвшил, Монгол хэл, Математикийн хичээлийн үр дүнг сайжруулан ажиллаж байна. 2015-2016 оны хичээлийн жилд талх нарийн боов, оёдол эсгүүр, мал аж ахуйн тоног төхөөрөмж хийх аргуудыг түшиглэн, ББНОХ, ХБЦНХ-ийн 62 сурагчийн нийгэмшил төлөвшил, Монгол хэл, Математикийн хичээлийн үр дүнг сайжруулахаар хичээллэсэн.

2016- 2017 оны хичээлийн жилд гар урлалын дугуйлан хичээллүүлж, цаасан нугалмай хийх, фото зураг авах чадвар эзэмшүүлэн, ББНОХ-ийн 4 хүүхэдтэй ажиллаж байна. ББНОХ-т хамрагдаж буй хүүхдүүд нь хөгжлийн бэрхшээлийн улмаас сургуулийн сурагчидтай зэрэгцэн суралцах, ачаалал даах, биеийн чадамжаас шалтгаалан танхимаар хичээллэх боломжгүй байдаг. Харин өөрсдийнх нь сонирхсон үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэх боломжийг хайж, бусадтай зэрэгцэн суралцах боломжийг нээж, бүлгийн ажилд оролцуулж байна.

ҮР ДҮН ҮР НӨЛӨӨ: Хүүхдүүдийн чадвар бодитоор ахиж байгаагийн дээр хүүхэд бүрт сонирхолтой байгаа тул бүх дугуйлан ирц, хамрагдалт бүрэн байдаг. Хүүхэд өөрийгөө нээн хөгжүүлж, хөтөлбөрт идэвхтэй оролцон, мэдлэг чадвараа тэлж, хийсэн бүтээлээсээ урам авч, өөрөөрөө бахархах сэтгэлтэй болж, аливаа зүйлийг хамтран хийхэд суралцаж байгаа ба тэр дундаа цаг баримталж сурсан нь хамгийн бахархуштай.

Оёдол эсгүүрийн дугуйланд: Улавчны эсгүүрийг хүүхдүүд өөрсдөө хэмжиж, эсгэж, хайчилж, дугаарлаж, оёдлын цахилгаан машинаар 16 төрлийн оёдол хийж сурсан. Сурагчид өөрсдийнхөө хэмжээг тодорхойлж, хэдэн размерийн хувцас өмсдөг болохоо мэддэг болсон. Дэрний уут, шагайны уут, сандлын бүрээсний хэлбэр, хэмжээ, өнгө, материалын орцыг

тооцож сурсан. Улавч хийх материал бөх байхгүй бол амархан урагддагийг мэдэж авсан. Мөн улавчийг гутлын гадуур өмсөх учир цагаан байх нь тохиромжгүй зэргээр материалын энгийг зөв сонгох хэрэгтэйг ойлгосон.

Талх, нарийн боовны дугуйланд: Өөрийн гараар хийсэн бүтээл ямар үнэ цэнтэйг ойлгож, аливаа зүйлийг сайхнаар төсөөлөн бодох, өнгө үзэмж, гоё сайхныг ойлгох, санал бодлоо солилцох, юмны амт, үнэр, жин хэмжүүрийн ойлголттой болох зэрэг олон зүйлийг сурч байна. Тухайлбал, кекс том, жижгээс шалтгаалан жигнэх минут өөр өөр байдаг тул цаг хугацааны хэмжүүрийг мэддэг болсон. Нэг хайрцаг гурилаар хэдэн ширхэг кекс, торт хийх вэ? гэх зэргээр ажлын бодлого, пропорцын бодлого бодох аргаас суралцсан. Аливаад ариг гамтай хандах, хувцсаа цэвэр нямбай өмсөх, ажлын байраа цэвэрхэн байлгах гээд олон зүйлийг сурсан.

Мал аж ахуйн тоноглолын дугуйланд: Мал аж ахуй тоног хэрэгслийг энгийн аргаар хийж сурах, хаягдал материал ашиглан төрөл бүрийн зангилаа сүлжээс сурах анхан шатны мэдэгдэхүүнтэй болсон. 3 төрлийн зангилаа, тооно туших, хонин холбоо, мяндсыг гурваар сүлжих, дөрвөөр сүлжих аргуудыг сурсан. Өвсний боодол, мяндсаар гоёлын оосор, малын тоноглол, уяа, хүлэг хийж болдог талаар ойлголттой болсон. Бүтээл хийхдээ үйлдлийн дарааллыг зөв тогтоох нь чухал болохыг ойлгуулсан.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Заавал шинэ материал худалдан авах шаардлагагүй, багадсан, өмсөхгүй хувцсыг цуглуулан улавч, хормогч хийх боломжтой. Хүүхдүүд энгийн оёдол ашиглан гутлын улавч, дэрний уут, хормогч зэргийг оёж сурсан ба гарсан бүтээлүүдээ багахан үнээр борлуулж, дараагийн материалын эх үүсвэрийг олох боломжтой юм.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Орон нутгийн хөгжлийн санд багахан тэтгэлэг бичиж өгөх боломжтой. Бага ангийн багш нарын үнэлгээгээр сурагчдын идэвх санаачилга, сурлагад ахиц өөрчлөлт гарч байгаа тул сургуулиас сурагчдын хөгжүүлэх ХБЦНХ-ийн аргуудыг тогтмол хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж байхаар болсон.

СУРГАМЖ: 1-р ангийн сурагчид цагаан толгой үзэж дуусаагүй, бичиг үсэг мэдэхгүй тул бага ангийн сургалтын менежертэй зөвлөлдөн 2-3 дугаар ангийн сурагчдыг хамруулсан.



Сайн туршлага: ХҮҮХЭД БҮР СУРЧ ЧАДДАГ

Хэрэгжүүлэгч: СҮХБААТАР АЙМГИЙН
УУЛБАЯН СУМ



АГУУЛГА: Уулбаян суманд МНӨ байгуулагдахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ном, тоглоомын багц ашиглах хүсэлт гаргаснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн багцыг гаргасан билээ. Ингэснээр хараа, сонсгол, оюун ухаан, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүд эцэг эхийн тусламжтай ном, тоглоомтой нөхөрлөн, бусад хүүхдийн адил хөгжих боломж бүрдсэн юм. Ном, тоглоомын багцаа ашиглаж дууссан, хөгжлийн ахиц гаргасан хүүхдүүд ББНОХ-өөр үргэлжлүүлэн суралцаж байна. Эцэг эхчүүдийн хувьд ч гэр бүлийн орчинд хүүхдээ хөгжүүлэх аргазүйд суралцахаас гадна хүүхдийнхээ боловсролд анхааран тусгай сургуульд хамруулах, ББНОХ-ийн модулийг судлуулах зэргээр хүүхдийнхээ сурах, хөгжих эрхийг хангахад идэвх зүтгэл гаргаж байна. Эцэг эхчүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд Уулбаян сумын ОНБЗ-ийн хамт олон идэвх санаачилгатай ажиллаж байгаа ба жил бүрийн 9 дүгээр сард сургуулиас завсардсан болон сургуульд огт сураагүй хүүхдүүдийг илрүүлэх судалгааг ЗДТГ, багийн дарга, сургуулийн удирдлагууд хамтран хийж, хамгийн түрүүнд боловсролд хамруулдаг. Боловсролд хамруулах явцдаа эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучилж орон нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа сайтай ажилладаг. Тухайлбал:

- *Халамжийн ажилтан:* Эцэг эхэд хуулийн талын мэдээлэл өгөх ба хүүхэд халамжийн ямар нэг хөнгөлөлтөд хамрагдах нь зайлшгүй бол бүрдүүлэх бичиг баримтын мэдээлэл өгөх зэргээр зөвлөмж өгнө.
- *Эрүүл мэндийн төвийн ажилтан:* Хүүхдийн бэрхшээлийг хөнгөвчлөх ямар эмчилгээ, хяналт байж болохыг зөвлөн, үйлчилгээ үзүүлнэ. Жишээ нь саажилттай хүүхдэд физик эмчилгээ хийнэ.
- *Багийн дарга, ОНБЗ-ийн дарга:* Эцэг эхчүүд, олон нийтийн хандлагыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд “Манай хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, юм сурахгүй... нас нь явчихлаа, дийлэхгүй дээ” гэх мэтчилэн сөрөг хандлагатай байсан ч хандлага нь ихээхэн өөрчлөгдсөн.

- **Сумын удирдлага:** Хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй ч хүүхдээ сурч, хөгжихөд нь дэмжин ажиллаж буй өрхүүдэд очих унааны зардал болон үр дүнгийн баяр, шинэ жилийн баяруудад гарын бэлгээ гардуулан сэтгэлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Тусгай ном, тоглоомыг ашигласнаар хүүхдүүдийн хувьд ном уншуулах, өөрөө номын зураг харах дуртай болж, гэр бүлийн гишүүдээс өөр хүмүүстэй харьцах сонирхолтой болсон. Багшийг гэрт нь очих үед баярлаж, дотноор ярилцдаг болсон. Хүүхдүүд ирээдүйд бие даан амьдрахад хувь нэмрээ оруулж байна. Олон нийтийн оролцоотойгоор боловсролын гадна хүүхэд үлдээлгүй илрүүлэн судалж, сум орон нутагт хамтран ажиллах боломж бүхий харьяа байгууллага, мэргэжилтнүүдийг баг болгон эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажилласны дүнд тогтсон арга барил, систем бүхий дэмжлэг бий болж байна. Өөрөөр хэлбэл эцэг эхчүүд ОНБЗ-өөр дамжуулан өвчний болон хөгжлийн бэрхшээлийн улмаас сургуульд суралцаж чадахгүй байгаа хүүхдүүдийг хөгжүүлэх боломжтойг мэдэж, хандах хүнтэй болсон.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан багц, ББНОХ-ийн модуль байхад бүрэн хэрэгжих боломжтой. Насан туршийн боловсролын багш эцэг эхчүүдэд хүүхэдтэйгээ ажиллах аргазүйн болон сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэн, зөвлөн тусалж ажиллавал эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ хөгжүүлэх, сургуульд сургахад их анхаардаг.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Уулбаян сумын хувьд сургуулийн нийгмийн ажилтан, номын санч, насан туршийн боловсролын багш багийн дарга нараас тогтмол судалгаа авч, жил бүр тодотгол хийдэг. Ингэснээр жил бүр шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах эрхийг ханган ажиллах боломж нөхцөл бүрдэнэ. Ном, тоглоомын багц, ББНОХ-ийн талаар олон нийтэд мэдээлэл хийх ба зорилтот хүүхдүүдэд гэрийн эргэлт хийж, зөвлөн туслах ажлыг тасралтгүй зохион байгуулна.

СУРГАМЖ: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад нэг зүйлийг маш олон удаа давтдаг тул уйгагүй хэлж өгөх, тэвчээртэй хүлээх чадварыг чиглүүлэгч багшаас шаарддаг. Эцэг эхчүүдэд хүүхэдтэйгээ ажиллахад тулгардаг бэрхшээлийн талаар ярилцах, зөвлөгөө өгөх, хандлага өөрчлөх ажлуудыг тасралтгүй хийх нь чухал.



4

ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛЫН
ЗӨВЛӨЛ, ОРОН НУТГИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНД ГАРСАН
САЙН ТУРШЛАГА



Сайн туршлага: **ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ**
Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН
ӨНДӨР-УЛААН СУМ**

АГУУЛГА: ОНБЗ-ийн гишүүд болон чиглүүлэгч багш нар малчин гэр бүлд өдөр тутамд хүрч ажиллах боломж хязгаарлагдмал тул 5 багт бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, бусдад зөвлөн туслах чадвартай, ярих чадвар сайтай, амьдралын түвшин боломжтой 50 ээжийг сонгож, хот айлын сургагч

багшаар бэлтгэж байна. Эдгээр сайн дурын сургагч багш нар нь хариуцсан хот айлынхаа боловсролын хэрэгцээг судлан тэдэнд туслах, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг ОНБЗ-тэй хамтран зохион байгуулах, төслийн мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэх, эргэх холбоог тогтоох зорилготой. Багийн засаг дарга нараас малчин өрх бүрийн гар утасны мэдээллийг цуглуулан, хот айлын чиглүүлэгч багш нарт түгээн, мэдээлэл солилцох утасны дугаар, хүний нэрс бүхий жагсаалттай холбоо барих дэвтэр бэлтгэн өгч мэдээлэл солилцох сүлжээ үүсгэсэн.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Иргэдийг мэдээллээр жигд хангаж, малчин өрх бүрт цаг алдалгүй хүрч ажиллах боломж бүрдсэн. Иргэдээс саналууд ирж, сургагч багш нар шаардаж байгаа тул ОНБЗ-ийн гишүүдийн жил бүрийн төлөвлөгөөнд тусгах ажлын санаанууд цуглаж, хүссэн ч, эс хүссэн ч ажиллах, төлөвлөх, хийхээс өөр аргагүй байдал үүссэн сайн талтай. Ингэснээрээ төслийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх нөхцөл бүрдэж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Бүх суманд хэрэгжих боломжтой, мөн үйл ажиллагааг өөрчлөх, өөр өөрийн сумын заншил, онцлогт тохируулан засан сайжруулан ажиллах бүрэн боломжтой. Бэлтгэгдсэн хүний нөөц бий болсон үед зохион байгуулах ажлын цар хүрээг өргөсгөж, шинэчлэн ажиллаж болно.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Хот айлын сургагч багш нарын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээг иргэдийн оролцоотойгоор хийж дүгнэх, давтан сургах, урамшуулах ажлыг тогтмол хийж чадвал үйл ажиллагаа тасалдахгүй. Урамшууллын системийг үзвэр үйлчилгээнд үнэгүй хамруулах зэргээр шинэлэг байдлаар явуулж болно.

СУРГАМЖ: Хүн ам ихтэй, нутаг дэвсгэр тархай, аймгийн төвтэй ойр сум учир иргэдийн шилжилт хөдөлгөөн их байдаг. Өөр аймаг, сумаас айлд шилжин ирэх хүүхдүүд Эрдэнэмандал сум, аймгийн төвд сургууль, цэцэрлэгт хамрагдах зэргээр хүүхдийн тоо мэдээлэлд ойр ойрхон засвар орох, хүүхэд хоцрох гэх мэт эрсдэлүүд гарсан тул энэхүү арга барилаар ажиллаж, бүх багийн малчин өрхөд хүрч ажиллах болсон.

Сайн туршлага: **ОНБЗ-ИЙНХНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА**
 Хэрэгжүүлэгч: **АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ СУМ**



АГУУЛГА: ОНБЗ байгуулагдсан цагаас эхлэн төслийн гишүүн бүр өөр өөрийн хийж чадах зүйл, давуу талаа тодорхойлон, түүндээ тулгуурлан ГБСОБХ, ХБЦНХ, ББНОХ-ийн хүрээнд идэвх санаачилгатай ажиллаж, мөн төслийн үйл ажиллагаанд оролцох гишүүдийн оролцоог жигд байлгаж, тогтвортойгоор ажиллаж хэвшсэн. Бидний хэрэгжүүлдэг үйл ажиллагаа ОНБЗ-ийн гишүүдийн ажил үүргийн хуваариас гадна хүн бүрийн оролцоог хангах, иргэд олон нийтийг татан оролцуулах, төслийн үйл ажиллагааг түгээх, таниулахад чиглэдэг.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: ОНБЗ-ийн гишүүн бүрт үүрэг, хариуцлага хүлээлгэснээр баг болж ажиллаж, аливаа үйл ажиллагаанд багаараа оролцдог.

Гишүүдийн нэр	Мэргэжил ба өөрийн чадвар	Улирал бүрээр төлөвлөн хийдэг үйл ажиллагааны агуулга	Гарсан үр дүн, үр нөлөө
Атарсайхан ОНБЗ-ийн дарга	Биеийн тамирын багш, илтгэх урлагийн чадварыг нэмэгдүүлэх	Хүүхдүүдийг өөртөө итгэлтэй болгож, илтгэх арга, ярих чадварт суралцуулдаг.	Хүүхдүүд өөртөө итгэлтэй болсноор өөрийн үзэл бодлоо насанд хүрэгчдэд зөв илэрхийлж, ойлгуулж, нийгэмшиж байна.
Гантулга ОНБЗ-ийн нарийн бичгийн дарга	Математикийн багш, шатрын спортыг хөгжүүлэх	Хүүхэд, эцэг эхэд шатар, даам зааж сурган оюун ухааныг хөгжүүлдэг. Хүүхдийн, эцэг эхийн, гэр бүлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, оны аварга тодруулж алдаршуулдаг.	Хүүхэд, эцэг эхийг дотносуулж, оюун ухааныг хөгжүүлж, идэвхжүүлдэг. Багш, хүүхэд, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирдаг.
Мөнхбат ОНБЗ-ийн гишүүн 3-р зорилтыг хариуцдаг	Багш, бичиг баримт хөтлөлт, бичгийн чадварыг хөгжүүлэх	Хүүхдийн ахицыг баримтжуулж, дүгнэлт бичих чадварт чиглүүлэгч багш, бага ангийн багш нар, номын санчид зөвлөгөө өгч хамтран ажилладаг.	ОНБЗ-ийн гишүүдийн бичиг баримтын хөтлөлт сайжирсан бөгөөд хүүхдүүдийн бичгийн чадвар нэмэгдэж байгаа.

М.Батболд ОНБЗ-ийн гишүүн, эцэг эхийн төлөөлөл. Төслийн түгээн дэлгэрүүлэлт хариуцдаг	Байгаль хамгаалагч, амьдрах ухаанд сургах, эх орон, байгаль дэлхийгээ хайрлах мэдлэг, төлөвшил олгох	Хүүхэд, эцэг эх, багш, сумын төрийн байгууллагуудад эх орноо хайрлах, байгаль орчноо хамгаалах, мод тарих зэрэг мэдээлэл өгөх, мод тарих өдөртэй болох, ХХТ-ын хүүхдүүдэд ардын уламжлалт ухааныг сургах, монгол гэр нүүлгэх, барих, мод ачих буулгах зэрэг уламжлалд сургаж, баримлын шавар, мод, цаасаар бүтээл хийлгэдэг.	Хүүхдүүд амьдрах ухаанд суралцаж, нийгмийн идэвх сайжирч, хүүхэд хүүхдээсээ суралцаж байна.
Сүрэнхорлоо ОНБЗ-ийн гишүүн. 1-р зорилт хариуцдаг	Цэцэрлэгийн багш, зураг зурах, хайчилбар хийх чадварт сургах	Хүүхдүүдийг зураг зурах, хайчилбараар бүтээл хийх аргуудад суралцуулж, ГБОСБХ- ийн хүүхэд, эцэг эхчүүдийн хамтын бүтээлийн сантай болгох зорилготой ажилладаг.	Хүүхэд эцэг эхийн бүтээлийн сантай болж байна. Зураг зурахдаа дан цаас харандаа ашиглах биш даавуу, эсгий дээр бүтээл урлаж, сэтгэлгээгээ өөрчилж, бүтээлээ баяжуулж байна.
Б.Батболд ОНБЗ-ийн гишүүн, ЗДТГ-ын төлөөлөл	Эрх зүйч, хүүхэд өөрийгөө хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварт сургах	Хүүхдүүдийн мэдэж байх хэрэгцээтэй хууль эрхзүйн мэдлэгийг ХБЦНХ-ийн аргазүйг ашиглан олгодог, мэдлэгийг АХА, Алтан хонх зэрэг уралдаан тэмцээн зохион байгуулж бататгадаг.	Хүүхдүүд өөрт үйлчлэх хууль, эрхзүйн мэдлэгийг багаасаа эзэмшиж, өөртөө тохиолдох эрсдэлээс хамгаалж сурч байгаа.
Оюун-Эрдэнэ ОНБЗ-ийн гишүүн. 2-р зорилт хариуцдаг	Дотуур байрын багш, эд хөрөнгийн баяжилт хийх, ариг гамтай эдлэх аргад суралцуулах	Дотуур байр, номын сангийн эд хөрөнгийг удаан эдэлгээтэй байлгах, баяжилт хийх ажлыг зохион байгуулж, дотуур байрын ахлах ангийн сурагчид, номын санчтай хамтран ном, тоглоомыг угааж цэвэрлэх, эцэг эхэд сургалт хийх ажлуудыг явуулдаг.	Ном, тоглоом, бусад эд хөрөнгийг гамтай эдлэх, олон хүүхдэд хүргэх, эцэг эхийн сэтгэлгээг өөрчлөх зэрэгт ахиц гаргаж байна.

Итгэлмаа ОНБЗ-ийн гишүүн. Мэдээлэл, оролцоо хариуцдаг	Нийгмийн ажилтан, хүүхдийн оролцооны бүлгийн үйл ажиллагааг чиглүүлэх, эцэг эх, олон нийтийг татан оролцуулах, хөтөлбөрүүдийг нутагшуулах шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Төслийн үр дүн, үйл ажиллагаа, аргазүйг иргэд олон нийтэд сурталчилахаар гарын авлага боловсруулан түгээдэг, сургуулийн орчин дахь эрсдэлийг бууруулах зорилгоор “амар тайван амьдрал-аз жаргал” 3 сарын аян, хүүхдүүдийг баярлуулах, хүслийг биелүүлэх зорилгоор “Мөрөөдөл биелдэг юм” 3 сарын аяныг санаачлан зохион байгуулж байна.	Тасралтгүй, үр дүнтэй ажиллах сургамж аван, үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. Цаашид эцэг эх, олон нийтийг татан оролцуулах, нутагшуулах шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
Баттулга ОНБЗ-ийн гишүүн 2-р зорилт хариуцдаг	Биеийн тамирын багш, хүүхдүүдийн дуу дуулах чадварыг нээх, хөгжүүлэх	Дуу дуулах сонирхолтой 10 хүүхдийг сонгон авч шинэ дуу зааж, дуу сурсан хүүхдүүд бусдадаа түгээдэг. МНӨ-ний, ХХТ- ын дуучин хүүхдүүд шалгаруулж ажилладаг.	Ирээдүйд дуучин болох хүүхдүүдийн бэлтгэл хангасан ажил болж байна.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: ОНБЗ-ийн гишүүн бүрт өөрийн мэргэжлээс гадна авьяас, чадвар байдаг. Хүн бүр өөр өөрийн чадварыг өөртөө итгэлтэйгээр зөв тодорхойлох, баг болж ажиллах, хамгийн гол нь хүүхдийн төлөө ажиллах итгэл, сэтгэлтэй байвал сайн баг болон ажиллаж чадна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Цаашид ОНБЗ-ийн гишүүд үйл ажиллагаагаа төлөвлөхдөө нэг удаа хийгдээд дуусах ажлыг биш, тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагааг төлөвлөж, үр дүн гаргахыг гол болгох хэрэгтэй. Мөн өөрсдөө бүгдийг гардан хийхээс илүү хүүхэд, эцэг эх, олон нийтийг санаачилгаараа оролцуулах аргыг илүү баримтлан ажиллана.

СУРГАМЖ: Төслийн эхний жилүүдэд ОНБЗ-ийн гишүүд хагас жилд нэг үйл ажиллагаа зохион байгуулдаг, үр дүн гарах нь бага, уралдаан тэмцээнээр хязгаарлагддаг байсан. Үүн дээрээ дүгнэлт хийж, үйл ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна.



Сайн туршлага: **ОНБЗ, ОРОН НУТГИЙН
УДИРДЛАГЫН ХАМТЫН
АЖИЛЛАГАА**


Хэрэгжүүлэгч: **ДОРНОД АЙМГИЙН
ЦАГААН-ОВОО СУМ**

АГУУЛГА: ГБОСБХ, ББНОХ-ийн хүрээнд багийн засаг дарга нар идэвх санаачилгатай ажиллаж байна. Тухайлбал ГБОСБХ-ийн судалгаа гарган, байнгын судалгаанд тодотгол хийх, эцэг эхчүүдэд сургалтын зар өгөх, багц солих (өвөлжилт хүндэрсэн

үе болон ажлын шугамаар явах бүрт), 96 өдрийн хичээл, ном, тоглоомын багцаа ашиглаж байгаа байдалд ажиглалт хийн зөвлөгөө өгөх, шинээр хүүхэд нэмэгдэн нүүж ирсэн эсэх зэрэг мэдээллийг багийн дарга нар өгч, хамтран ажилладаг болсон. Малчин иргэдтэйгээ нийгмийн асуудлаар уулзах бүртээ тухайн өрхийн хүүхдийнх нь боловсролд анхаарал хандуулж байгаа нь малчидтайгаа илүү ойр дотно ажиллах, тэдний ахуй амьдралд өөриймсөг ханддаг болгож, хамгийн чухал нь бие биедээ итгэх итгэлцлийг бий болгосон.

Сумын засаг даргын хувьд багийн дарга нарын ажил үүргийн хуваарьт хөтөлбөрийн үр дүнг тусгай нэг үзүүлэлт болгон тусгаж, үр дүнг хэлэлцэн ажиллаж хэвшсэн. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн бодлогод ГБОСБХ-ийн хүрээнд багийн дарга нарын гэрийн эргэлтийн түлшний зардал, ном, тоглоомын багцын сэлгэлт хийх зардал, дотуур байрын 2-р байранд ХХТ-ыг шинээр байгуулах зардал болон хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг дэмжин 2.9 сая төгрөгийн санхүүжилтийг суулган ажилласны үр дүнд олон асуудал шийдэгдсэн.

ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: Сум, орон нутгийн удирдлагуудын хүүхдийн боловсролд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсэн. ГБОСБХ, ХБЦНХ, ББНОХ-ийн талаарх ойлголт нэмэгдсэн. Хамтын оролцоо чухал гэдгийг бүх түвшинд ойлгосон. Багийн дарга нар хүүхэд дээр ажиглалт тэмдэглэл хийж сурсан ба судалгаа хийх чадвартай болсон. Хүүхдийн боловсролоор дамжуулан орон нутгийн иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх боломжтой гарцыг олж харсан. Багийн дарга нар болон ОНБЗ-ийн дарга нар 7 хоног бүрийн шуурхай хурал дээр хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгдөг болсон. Жил бүр дотуур байранд суух



6-10 насны хүүхдийн тоо 3-5-аар өсөж байгаа. Залуу малчин өрхийн тоо 7-10-аар нэмэгдсэн төдийгүй тогтмол өсөх хандлагатай байна.

ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ: Сумын засаг дарга нар жил бүр мөрийн хөтөлбөр болон нийгэм, эдийн засгийн бодлогод малчдын хүүхдийн боловсролын асуудлыг тусгах замаар ГБОСБХ, ББНОХ-ийг санхүүжүүлэх боломжтой. Багийн дарга нарын ажил үүргийн хуваарь болон үр дүнгийн гэрээнд тусган ажиллах, орон нутгийн хөгжлийн сан, сумын давсан орлогоос хөрөнгө оруулалт хийх боломжтой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Сумын нийгэм, эдийн засгийн төлөвлөлтөд оруулан хөрөнгө босгох боломжтой. Холбогдох хүмүүсийн ажил үүргийн хуваарьт нэмэлтээр оруулж, үр дүнгийн гэрээнд тусгасан учир тогтвортой хэрэгжинэ. ОНБЗ өөрөө сайн дурын идэвхтэн ажиллуулах замаар хөгжүүлж болно.

СУРГАМЖ: 4 жил тутамд сонгууль болж орон нутгийн удирдлага солигддог боловч иргэдийн оролцоог идэвхжүүлэн ажилласнаар боловсролыг тасралтгүй олгох, хөрөнгө оруулалт хийх, удирдлагад нөлөөлөх боломжтой. Сонгуулийн дараа байгуулагдсан шинэ удирдлагуудад цаг алдалгүй мэдээлэл өгч хамтран ажиллах хэрэгтэй.



Сайн туршлага: **СӨББ, СУРГУУЛИЙН
ЗАЛГАМЖ ХОЛБОО**
Хэрэгжүүлэгч: **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
УЯНГА СУМ**

АГУУЛГА: Уянга сумын НТБТ, СӨБ-ын багш нар хамтран ГБОСБХ-ийг орон нутагт нутагшуулах зорилгоор СӨББ-ЕБС-ийн залгамж холбоог сайжруулж, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэн, сурах арга барилыг хүүхэд насанд нь олгож байна.


ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ: 2014 оноос ГБОСБХ-ийг НТБТ-ийн багш нар хариуцан явуулж байсан ба 2015 онд цэцэрлэгийн ээлжийн бүлэгтэй хамтран зуны сургалтаар, 2016 онд 3 ээлжээр хөтөлбөрийг хэрэгжүүлдэг болсон.

I үе шат, бэлтгэл үе: 2014 оноос эхлэн сумын нийгмийн хамгааллын баг, хүүхэд хамгааллын баг, багийн засаг дарга нартай хамтран хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаснаар 2014 онд 150, 2015 онд 141, 2016 онд 160 хүүхдийг хөтөлбөрт хамруулсан.

2014 онд хөтөлбөрт хамрагдсан 141 хүүхдийн сургалтыг сумын НТБТ-д ажиллаж буй үндэсний сургагч багш Б.Ариунаа, О.Оюунцэцэг, Ж.Пүрэвсүрэн, Ш.Батцэцэг нар зохион байгуулж явуулсан. Түүнчлэн СӨББ-ын 24 багшийг орон нутгийн сургагч багшаар бэлтгэсэн. Хүүхэд тус бүрийн бие бялдар, нийгэмшихүйн хөгжил, хэл ярианы хөгжил, бүтээлч илэрхийллийн чадвар, хүрээлэн буй орчны харилцаа гэсэн 5 чиглэлээр 50 асуулгаар судалснаар гарааны, явцын, эцсийн үнэлгээг гаргаж тооцох аргачлалыг боловсруулсан.

II үе шат, сургалтын үе: 2015 онд СӨББ-ын зуны сургалттай хамтран хөтөлбөр боловсруулж, эцэг эхийн сургалтыг чиглүүлэгч багш нар зохион байгуулж, СӨББ-ын багш нар хүүхдийн суралцсан байдалд үнэлгээ өгч туршиж ажилласан.

2016 онд НТБТ-ийн чиглүүлэгч багш нар эцэг эхийн сургалтыг зохион байгуулж, 10 хоногт 1 удаа зөвлөгөө өгч, эцэг эхчүүд хүүхэдтэйгээ гэрт нь хамтарч хичээллээд, СӨББ-ын багш нар хүүхдийн юу сурсан, эцэг эх нь хэрхэн хичээллэсэнд үнэлгээ өгч, самбараар дүгнэж



ажиллаж байна. Хичээлийг хэл яриа, математик тоолол, хөдөлгөөн эрүүл мэнд, зан чанар харилцаа, байгаль нийгмийн орчин, урлаг уран сайхан гэсэн чиглэлээр багцлан мөрдөж байна. Сургалтын явцад хүүхдүүдээр зураг зуруулж, баримлын шавар болон бусад зүйлээр бүтээл хийлгэж, бүтээл хийхэд нь эцэг эхийн оролцоо, дэмжлэгийг харгалзан ахицыг үнэлж, хичээл болгонд ном, тоглоомын багцын ашиглалтад үнэлгээ өгдөг юм.


III үе шат, үр дүнгийн үе: 2014-2016 онд 6 настай хүүхдүүдийг хөтөлбөрт 100% хамруулж, 1-р ангид шилжүүлж өглөө. Хичээлийн жил эхлэхэд сургуулийн орчинтой танилцах аялал хийлгэн, юу сурч мэдэж, сургуульд хэрхэн бэлтгэснийг тайлагнан 1-р ангийн багшид хүлээлгэн өгч хэвшсэн. Сургуульд суусан цагаас ЕБС-ийн бага ангийн багш нар хүүхдийг хөтөлбөрийн хүрээнд юу сурсан, хэрхэн хөгжсөнд тулгуурлан цаашид хөгжүүлэх, сурах арга барил эзэмшүүлэх бодит үнэлгээтэй болж байгаа юм. СӨББ-тай хамтран ажилласнаар хүүхдүүд СӨББ-ын орчинд орж хичээллэн илүү сонирхолтой болж, эцэг эхийн зүгээс хүүхдэдээ хандах хандлага, идэвх оролцоо нэмэгдсэнээс гадна хүүхдэдээ хичээл заах аргазүйд бие биенээсээ суралцах боломж нэмэгдсэн нь харагдаж байсан.

ХЭРЭГЖИХ БОЛОМЖ: Сумын ОНБЗ-ийн зүгээс сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д ГБОСБХ-ийн биелэлт, үр дүн, цаашид авч явах боломжийн талаар танилцуулан, хэлэлцүүлж цаашид энэхүү хөтөлбөрийг СӨББ-ыг түшиглүүлэн зохион байгуулах тогтоол гаргалаа. Ингэхдээ НТБТ-ийн сургагч багш нар эцэг эхийн сургалтыг, эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээлийг зааж, СӨББ хүүхдийн юу сурч, мэдэж, хөгжсөнийг үнэлж дүгнэж, ЕБС-д хүлээлгэн өгч байх журам боловсруулсан.

СӨББ, ЕБС-ийн алинд ч нэмэлт зардал гаргахгүйгээр хариуцсан багш ажилтнуудын ажил үүрэгт тусгагдаж, үр дүнгийн гэрээгээр баталгаажсан юм.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: Тус хөтөлбөрийг хэрхэн зохион байгуулж байгаад ОНБЗ хяналт тавьж ажиллах бөгөөд жилд 2 удаа сумын ИТХ, засаг даргын зөвлөлд үр дүнгээ тайлагнадаг.

СУРГАМЖ: Цаг агаарын байдал, иргэдийн амьжиргаа, улирлын байдалтай уялдуулан сургалтын хугацааг уян хатан байлгах нь зүйтэй юм.



“АЛСЛАГДСАН ХӨДӨӨГИЙН МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДИЙН БАГА БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ НЬ” төсөл (2012-2017)

Төслийн санхүүжүүлэгч:	Дэлхийн Банк, Японы Нийгмийн Хөгжлийн Сан
Төсөл хэрэгжүүлэгч:	Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр
Төслийн санхүүжилт:	2.5 сая ам.доллар
Төслийн хугацаа:	5 жил (2012-2017)

Төслийн зорилго:

Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн алслагдсан 30 сумын 5-10 насны малчин өрхийн 7,500 орчим хүүхдийн бага боловсролын хүртээмж, чанар, үр дүнг сайжруулна.

Төслийн зорилт:

1. Сургуульд шинээр элсэн орох 5 настай хүүхдүүдэд зориулсан гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр шинээр боловсруулж, туршин нэвтрүүлнэ.
2. Гэр бүлээсээ тусдаа айлд болон дотуур байранд амьдарч буй 6-10 насны хүүхдүүдэд зориулсан хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
3. Сургуульд сураагүй болон бага ангидаа сургуулиас завсардсан 8-с дээш насны хүүхдүүдэд бага боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, туршин нэвтрүүлнэ.





Save the Children

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ secretary@savethechildren.mn

🌐 www.savethechildren.mn

📘 Save The Children in Mongolia

🐦 Save The Children MN

© Гэрэл зургуудын эрхийг Хүүхдийг Ивээх Сан эзэмшинэ.